



Засгийн газрын тохируулагч агентлаг
Үндэсний хөгжлийн газар



Шинжлэх ухааны академи
Газарзүй-Геоэкологийн хүрээлэн

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО СУДАЛГАА

Монгол Улсын эдийн засгийг бүсчлэн
хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогын
хүрээнд

М.Алтанбагана, доктор, дэд профессор, ШУА-ын
Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Нийгэм, эдийн
засгийн газарзүйн салбарын дарга

Улаанбаатар, 2018

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ АГУУЛГА

НЭГ. ОРШИЛ.....	5
1.1. Бодлогын судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлага.....	5
1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт.....	7
1.3. Судалгааны ажлын хамрах хүрээ.....	7
1.4. Судалгааны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө.....	7
ХОЁР. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ.....	9
2.1. Орон нутгийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээний хийх аргачлал.....	9
Шалгуур үзүүлэлтийн тухай.....	9
2.2. Хөгжлийн ирээдүй сайтай сум, сууринг тодорхойлох аргачлал.....	15
ГУРАВ. БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ.....	18
3.1. Бүсчилсэн хөгжлийн чанарын шалгуур үзүүлэлт.....	18
ДӨРӨВ. ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН ОРОН ЗАЙН АНАЛИЗ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГЛАЛ... 44	44
4.1. Хөгжлийн ирээдүй сайтай сум сууринг тодорхойлох шалгуур үзүүлэлт.....	46
4.2. Орон нутгийн хөгжил байршлийн анализ.....	48
4.2.1. Хүн ам, нийгмийн хөгжил, байршлийн зураглал.....	48
4.2.2. Эдийн засаг, үйлдвэрлэлийн салбарын хөгжил байршлийн зураглал.....	60
4.2.3. Дэд бүтцийн салбарын хөгжил байршлийн зураглал.....	68
4.2.4. Байгаль орчинтой холбоотой хөгжил байршлийн зураглал.....	75
4.2.5. Газарзүйн оновчтой байршлийн зураглал.....	81
4.2. Нэгдсэн орон зайн анализын дүн: Хөгжлийн ирээдүй сайтай сум, суурин газар ...	82
ТАВ. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ СХЕМ, ХАВСРАЛТУУД.....	91

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

№	Зургийн нэр	Хуудасны дугаар
1	Орон нутгийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээний хийх аргачлалын үе шат	9
2	Аймаг, орон нутгийн бодлого, хөтөлбөрт бодлогын анализ хийх аргазүйн схем	15
3	Аймаг, орон нутгийн бодлого, хөтөлбөрийн стратегийн зорилт, дэд зорилт	24
4	Архангай аймгийн хөгжлийн цогц бодлого 2011-2021 он	31
5	Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008-2021 он)	32
6	Баянхонгор аймгийн хөгжлийн хөтөлбөр (2006-2020)	33
7	Баян-Өлгий аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2021)	33
8	Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он) Дархан-Уул аймгийн “Хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”	33
9	Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (2003-2020) Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)	34
10	Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого (2002-2020) Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/	34
11	Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилт (2016-2025)	35
12	Дундговь аймгийн 2020 он хүртлэх хөгжлийн бодлого	35
13	Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)	35
14	Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)	36
15	“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он)	36
16	Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөр /2007-2021 он/	36
17	Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)	37
18	Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр /2008-2021 он/	37
19	Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021 он)	37
20	Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого	42
21	Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого	43
22	Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	43
23	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого	43
24	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	44
25	Ноолуур хөтөлбөр	44
26	Ногоон хөгжлийн бодлого	44
27	Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр	45
28	Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	45
29	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого	45
30	“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр	46
31	“Аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	46
32	“Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөр	46
33	Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого	47
34	Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн тогтолцоо, Бүсийн тулгуур төв хотын байршил	48

35	Хот, тосгон болон сум суурин газар, хүн амын тооны ангиллаар, 1996 он	63
36	Хот, тосгон болон сум суурин газар, хүн амын тооны ангиллаар, 2006 он	63
37	Хот, тосгон болон сум суурин газар, хүн амын тооны ангиллаар, 2017 он болон Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор	64
38	Хүн амын өөрчлөлт: 1990-2000 оны хооронд хүн амын жилийн дундаж өсөлт, бууралт, %	69
39	Хүн амын өөрчлөлт: 2000-2010 оны хооронд хүн амын жилийн дундаж өсөлт, бууралт, %	69
40	Хүн амын өөрчлөлт: 2010-2017 оны хооронд хүн амын жилийн дундаж өсөлт, бууралт болон Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор	70
41	Боловсролын үйлчилгээний зураглал, сумдын түвшинд	74
42	Эрүүл мэндийн үйлчилгээний зураглал, сумдын түвшинд	75
43	Эдийн засгийн чадавхийн үнэлгээ, сумдын түвшинд	76
44	Уул уурхай, ашигт малтмалын байршил, дэд бүтцийн хөгжлийн зураглал	77
45	Уул уурхай, ашигт малтмал болон Хүнд үйлдвэрлэлийн төслийн байршлийн зураглал	78
46	Малын тооны өсөлтийн тархалтын зураглал, сумдын түвшинд	79
47	Малын тоо, толгойн нөөцийн тархалтын зураглал, сумдын түвшинд	80
48	Арьс, ширний нөөцийн тархалт ба Хот, сумд болон дэд бүтцийн байршил, сумдын түвшинд	81
49	Боломжит ноосны нөөцийн тархалт ба Хот, сумд болон дэд бүтцийн байршил, сумдын түвшинд	82
50	Боломжит ноолуурын нөөцийн тархалт ба Хот, сумд болон дэд бүтцийн байршил, сумдын түвшинд	83
51	Авто замын нэгдсэн сүлжээ (Одоо байгаа & төлөвлөгдсөн)	84
52	Төмөр замын нэгдсэн сүлжээ (Одоо байгаа & төлөвлөгдсөн)	85
53	Одоо байгаа болон төлөвлөгдсөн авто замын сүлжээ ба Хот, сумдын байршил	86
54	Одоо байгаа болон төлөвлөгдсөн төмөр замын сүлжээ ба Хот, сумдын байршил	87
55	Сумын төвийн цэвэр ус хангамж, ариутгах шугам сүлжээ, сумдын түвшинд	88
56	Сумдын төвийн дулаан хангамжид холбогдсон байдал, сумдын түвшинд	89
57	Эрчим хүчний хангамж, сүлжээ ба Хот, сумдын байршил, сумдын түвшинд	90
58	Байгалийн бүс бүслүүр ба сумдын байршил	91
59	Экологийн бүсүүд дэх сумдын тоо	91
60	Уур амьсгалын өөрчлөлтийн орон зайн тархалт нөлөө ба Хот, сумдын байршил	92
61	Томоохон гол, нуурын сүлжээ болон Хот, сумдын байршил	94
62	Гадаргын усны нөөц ба Хот, сумдын хүн амын тоо, байршил	96
63	Бүлэг суурингийн тогтолцоо	97
64	Хөгжлийн ирээдүй сайтай сум, суурин газар	98

ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ

№	Хүснэгтийн нэр	Хуудасны дугаар
1	Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгааны төлөлөгөө	7
2	Ажлыг дуусгаж тайлан өгөх хуваарь	9
3	Аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр	13
4	Бүсчилсэн хөгжлийн агуулгаар Үндэсний, салбарын болон орон нутгийн хөгжлийн баримт бичигт бодлогын шинжилгээ хийх “Шалгуур үзүүлэлт”	19
5	Аймгуудын хөгжлийн хөтөлбөрийн зорилт, дэд зорилтууд (салбарын бодлогоор)	25
6	Аймгуудын хөгжлийн хөтөлбөрт Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлт тус бүрт нийцэж байгаа зорилт, арга хэмжээ, тоо	27
7	Үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөр	38
8	Үндэсний бодлого, хөтөлбөрүүдэд шалгуур үзүүлэлт тус бүрийн тусгагдсан тоо	39
9	Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн тогтолцоо, хамрах аймаг, тулгуур төв хот ^{1,2}	48
10	Хөгжлийн ирээдүй сайтай сум сууринг тодорхойлох шалгуур үзүүлэлт	51
11	Монгол Улсын эдийн засгийн бүсүүдэд хамрагдах хот, тосгон болон сум, суурин газар, хүн амын тооны ангилал болон 1996, 2006, 2017 оноор	65
12	Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын дагуух бүс нутгийн хот, тосгон, болон сум суурин газрын хүн амын нутагшилт, суурьшлийн гео-орон зайн анализ, шинжилгээ, 2017 оны байдлаар	65
13	Хүн амын өөрчлөлт, хүн ам нь өссөн болон буурсан аймгийн төв, сумдын тоо	71
14	Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын дагуух аймгийн төв болон сумын төвийн хүн амын өөрчлөлт, 2017 оны байдлаар	71
15	Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, суурин, сумын төв, тосгон	95
16	Хөгжлийн ирээдүй сайтай сум, суурингийн газар	99

¹ Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. Улаанбаатар.

² Бүсийн тулгуур төв хот тогтоох тухай. УИХ-ын 2003 оны 01 дугаар тогтоол. Улаанбаатар.

НЭГ. ОРШИЛ

1.1. Бодлогын судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлага

Өргөн уудам газар нутагтай, хүн ам цөөнтэй, ашигт малтмалын болон хөдөө аж ахуйн нөөц ихтэй Монгол Улсын хувьд нийгэм, эдийн засгийг жигд, хүртээмжтэй, тэгш байдлаар бүсчлэн хөгжүүлэх асуудал нэн чухал болно.

Монгол Улсын Үндсэн хуульд Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд "... бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх" тухай заалт тусгагдсан нь Бүсчилсэн хөгжлийн тухайд баримтлах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх эрхзүйн үндэс боддог.

2000-аад оны үед Монгол Улсын Их хурал, Засгийн газраас Бүсчилсэн хөгжлийн бодлоготой холбоотой эрхзүйн акт, үзэл баримтлал, стратеги, хөтөлбөрүүд батлагдан гарсан. Үүнд:

- Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2001
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, 2003
- Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги /2010 он хүртэл/
- Бүсийн тулгуур төв хотуудыг тогтоох тухай
- Зүүн, Баруун, Төвийн, Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр /2006-2015/
- Улаанбаатар бүсийн хөгжлийн хөтөлбөр /2006-2015/

Дээрх бүсчилсэн хөгжилтэй холбоотой бодлогын баримт бичгүүдийн суурь болох Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд "тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино." гэж тодорхойлсон. Энэ нь 2000-2005 оны үед боловсруулж, батлуулсан бүсчилсэн хөгжилтэй холбоотой бодлогын баримт бичгүүдийн гол үзэл баримтлал юм.

Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд хийгдсэн "Орон нутгийн хөгжлийн бодлогын судалгаа" нь Монгол Улсын "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах" бодлогыг үндэсний, салбарын, орон нутгийн бодлоготой уялдуулан боловсруулахад оршино.

Бүс нутгийн хүрээн дэх үндэслэл, хэрэгцээ шаардлага:

- Үндэсний хөгжлийн газар нь "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу "Бүсчилсэн хөгжлийн бодлого"-ыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн хамтран боловсруулах чиг үүрэгтэй. Мөн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2017 оны 15 дугаар тогтоолын 5 дугаар заалтад тус газарт

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах талаар чиглэл өгсөн.

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд баталсан бөгөөд одоогийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, олон улсын харилцаа тухайн үеийн нөхцөл байдлаас ихээхэн өөрчлөгдөөд байна.
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн боловсруулсан Монгол Улсын Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацаа (нэгдүгээр үе шат-2006-2010 он, хоёрдугаар үе шат-2011-2015он) дууссан.
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан шинээр боловсруулах шаардлагатай байна.
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулиудын уялдаа хангалтгүй, нутаг дэвсгэрийн нийгмийн харилцаа, орон зайн зохион байгуулалтыг оновчтой зохицуулдаг хуулийн нэгдмэл механизм болж үйлчлээгүйгээс шалтгаалж, үндэсний, бүс нутгийн хэмжээний хөгжлийн асуудлыг орон нутаг, салбарын бодлогоор зохицуулахыг эрмэлзэж байна.
- Даяаршлын нөхцөлд дэлхийн улсууд, түүний дотор хоёр хөрш орон болох ОХУ, БНХАУ-ын геополитик, геоэдийн засгийн чиг хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдөж, ОХУ нь Зүүн хойт Ази, Номхон далайн оруудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхийг зорих боллоо. БНХАУ нь Ази, Европыг холбож байсан торгоны замын худалдаа, эдийн засгийн харилцааг үндэслэн “Нэг бүс-Нэг зам” бодлогыг тодорхойлж, энэ чиглэлд татагдаж байсан бүх орон, түүний дотор Хятад-Монгол-Орос гурван улсын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг батламжилж, хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.

Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээн дэх үндэслэл, хэрэгцээ, шаардлага:

- Монгол Улсын өргөн уудам газар нутаг, орон нутгийн онцлог, түүний байгалийн баялаг, түүхий эдийн нөөцийг дотоод, гадаад зах зээлд бүрэн, зохистой ашиглаж, үр өгөөжийг нь зөв хуваарилаж ирээгүйгээс ажилгүйдэл, ядуурал ихсэж, хүн амын амьдралын түвшин жигд дээшилж чадалгүй, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хот болон уул уурхайн цөөн тооны төв суурин газар руу шилжин суурьших, гадаад оронд гарч ажиллах явдал үргэлжилж байна.
- Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрөл, байршилт нь эдийн засгийн үр ашгийг тогтвортой нэмэгдүүдэх өсөлтийн хүчин зүйл болхоосоо илүү, хүрээлэн буй орчны даац, чанарыг муутгаж, оршин суугчдын амьдрал, эрүүл мэндэд ноцтой нөлөөлсөн олон тооны

сөрөг үр дагаварыг бий болгож үндэсний аюулгүй байдлын түвшинд хүрээд байна.

- Төвлөрлийг сааруулах талаар хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр, Чөлөөт бүсүүд, аж үйлдвэрийн парк, бүсийн тулгуур төвүүдийн төслүүд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөв санхүүгийн бодлого, арга хэмжээтэй уялдаж чадаагүйгээс үр дүн хангалтгүй хэрэгжихгүй байгаа асуудал байсаар байна.

1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт

Орон нутгийн хөгжлийн бодлогын судалгааны зорилго нь орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, учир шалтгааныг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны үндсэн дээр 1). Бүсчилсэн хөгжлийн агуулгаар боловсруулсан шалгуур үзүүлэлтээр орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, цаашдын чиг хандлагад шинжилгээ хийх, 2). бүс нутгийн хөгжлийн бодлогын үүднээс орон нутгийн түвшинд хөгжлийн ирээдүй сайтай сум, сууринг тодорхойлох, хөгжил байршлын нэгдсэн төлөвлөлт, зураглалыг боловсруулж, улмаар Монгол Улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах” бодлогын баримт бичигт тусгана.

1.3. Судалгааны ажлын хамрах хүрээ

Монгол Улсын эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, тулгамдаж буй асуудлыг улс үндэсний (олон улсын түвшинд), бүсийн (хөрш болон, бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааны хүрээг хамруулан), аймаг, орон нутгийн түвшинээр харьцуулан судалж, шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлно.

1.4. Судалгааны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө

Орон нутгийн хөгжлийн бодлогын судалгааны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөөг дараахь хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1. Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгааны төлөвлөгөө

Үйл ажиллагаа (ажлууд)	Зөвлөхийн үйлчилгээг эхэлсэн нэг дэх сар, хоёр дахь сар гэх мэт				
	1	2	3	4	5
Бодлогын судалгааны аргазүй, аргачлал, хамрах хүрээг эцэслэн тогтоно.					
Бодлогын судалгаанд шаардлагатай мэдээ, материалыг бүрдүүлнэ					
Аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгнө.					

Нөхцөл байдлын дүн шинжилгээ: Орон нутгийн тулгамдсан асуудал, бэрхшээлийг тодорхойлох анализ, шинжилгээ хийж, дүгнэлт өгнө					
Эрхзүй орчин, үндэсний болон салбарын хөгжлийн бодлогод шинжилгээ хийж, дүгнэлт өгнө.					
Эхлэлтийн тайлан: Бүсчилсэн хөгжлийн болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд одоо мөрдөгдөж байгаа хууль, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдаж буй байдалд дүн шинжилгээ хийнэ					
Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно					
Аймаг, орон нутгийн хөгжлийн баримт бичиг Бүсчилсэн хөгжлийн агуулгаар шинжилгээ хийнэ					
Дунд хугацааны тайлан: Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан					
Орон зайн анализ хийж, орон нутгийн түвшинд хөгжил, байршлын зураглал хийнэ					
Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ					
Эцсийн тайлан өгөх					

Хүснэгт 2. Ажлыг дуусгаж тайлан хуваарь

Тайлан	Он, сар, өдөр
1. Эхлэлийн тайлан	2018.08.20
2. Явцын тайлан (а) 1 дэх тайлан (б) 2 дахь тайлан	2018.09.30
3. Тайлангийн төсөл	2018.10.30
4. Эцсийн тайлан	2018.12.10

Жич: гэрээ байгуулснаас хойш ойролцоогоор тооцолсон огноо бөгөөд, гэрээ байгуулсан нөхцөлд нарийвчлан тогтоно.

ХОЁР. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.1. Орон нутгийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээний хийх аргачлал


Үе шат I. Чанарын “Шалгуур үзүүлэлт” тодорхойлох тухай

Монголын нөхцөлд бүсчилсэн хөгжлийн хэмжүүрийг тодорхойлоход тооцох хүчин зүйлс. Улс орнууд үндэсний хэмжээнд бодлого зорилтоо тодорхойлохоос гадна бүс нутгийн хэмжээнд цаашлаад орон нутгийн түвшинд бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрөө боловсруулж түүнийгээ тогтмол хянаж, бодлого үйл ажиллагаа, ажлын явцаа дүгнэж байх нэн чухал. Бүсчилсэн хөгжлийн бодлого хөтөлбөрүүд нь оновчтой тодорхойлогдсон эсэх, зөв хандлага зарчмаар явж байгаа эсэхийг нягтлахад нарийн нягт боловсруулсан хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд чухал үүрэгтэй.

Иймд энэхүү судалгааны ажлын хүрээнд орон нутгийн түвшинд үнэлгээ хийж болохуйц Бүсчилсэн хөгжлийн шалгуурыг тодорхойлж, уг шалгуураар Үндэсний болон орон нутгийн бодлого, хөтөлбөрт шинжилгээ хийхийг зорьсон.

Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх төвлөрлийг сааруулах агуулгаар, эрхзүйн баримт бичигт тулгуурлан холбогдох Үндэсний болон салбарын бодлого, хөтөлбөр болон аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээ хийж, дүгнэлт өгөхдөө дараахь үе шат-аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

Зураг 1. Орон нутгийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээний хийх аргачлалын үе шат



Шалгуур үзүүлэлтийн тухай

Бодлогын шинжилгээ хийх “Шалгуур үзүүлэлт”-ийг тодорхойлохдоо бүсчилсэн хөгжлийн бодлоготой холбоотой, орон нутгийн түвшинд анхаарах шаардлагатай, бодлого төлөвлөлтийн хувьд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ нь дараахь агуулга, хэв шинжийг хамрах байдлаар тодорхойлсон болно. Үүнд,

- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал,

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол агуулга, бодлогын зорилуудад тулгуурлах
- *Доороос дээш*: Орон нутаг нь Үндэсний болон Бүс нутгийн түвшний хөгжилд ямар үүрэг роль гүйцэтгэх, бодлогын зорилтууд
- *Дээрээс доош*: Үндэсний түвшний бодлого, хөтөлбөрт нийцсэн эсэх. Өөрөө хэлбэл, *Үндэсний түвшний бодлого, хөтөлбөрөөс орон нутгийн түвшинд буулгаж хэрэгжүүлэх*
- Бүсчилсэн хөгжлийн онолын хандлага, үзэл санаа
- Бодлогын зорилтууд нь хэв шинжийн хувьд **хамтрах, өөр хоорондоо хоршин хөгжих** зорилт дэвшүүлсэн эсэх
- **Ижил төстэй** бодлогын зорилт байгаа эсэх
- **Нийтлэг болон ялгаатай** бодлогын зорилт
- Орон нутгийн хөгжлийн **нөөц, боломж**, тухайлбал, хөдөлмөрийн нөөц
- Орон зайн хөгжлийн хамаарал (нийгэм, эдийн засаг, байгаль орчин)

Бүсчилсэн хөгжилтэй холбогдуулан Үндэсний болон орон нутгийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээ хийх Шалгуур үзүүлэлтыг тодорхойлоход харгалзах үзэх суурь ойлголт (*keystones*)-ын асуудлыг бүрэн хамарсан байх шаардлагатай. Иймд Бүсчилсэн хөгжилтэй холбоотой харгалзах үзэх суурь ойлголтуудыг дор харууллаа. Үүнд,

- Эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрөл, хоршилт, төрөлжилт;
- Бүс нутгийн зах зээлийн өрсөлдөөн, худалдаа, экспорт, импорт;
- бүс нутаг-хотжилт-хөдөө нутгийн нэгдмэл орчныг бий болгох;
- Коридор /эдийн засгийн, тээвэр хөгжлийн, ногоон хөгжлийн г.м/;
- Босоо ба хөндлөн тэнхлэгийн бүсчлэл;
- Эдийн засгийн хөгжлийн бүс;
- Кластер: Бүс нутгийн хөгжлийг өрсөлдөх чадвар сайтай хэд хэдэн кластерийн байршилд авч үзэх;
- Кластерийг нэмүү өртгийн сүлжээ бий болгоход хүчтэй хамтран оролцож буй судалгааны институт, аж үйлдвэрийн дэд бүтэц, хэрэглэгч, үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн сүлжээ торлог хэлбэрээр авч үзэх;
- хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот сууринг тэргүүн ээлжинд сонгох, хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Бүсийг “ажлын байр бий болгох, таваар, импорт, экспортыг бий болгох, суурь эдийн засгийн нөөцөд суурилсан салбар хоорондын хамтын ажиллагаа бүхий нийгмийн, шинжлэх ухаан судалгааны, бизнесийн байгууллагуудын нэгдэл” хэлбэрээр авч үзэх;
- Бүс нутгийн аж ахуйн бие даасан байдлыг хангах.

Шалгуур үзүүлэлтийн тухай. Эхлээд шалгуур үзүүлэлтийн тухай товч авч үзье. Бүсчилсэн хөгжлийн тогтсон тодорхойлох шалгуур үзүүлэлт гэж байхгүй бөгөөд энэ нь Тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг хангах асуудалтай уялдуулан, тухайн улс орон өөрийн онцлог, нөхцөлд тулгуурлан харилцан адилгүйгээр тодорхойлж байна. Өөрөөр хэлбэл, Бүсчилсэн хөгжлийн бодлого, түүнд тавигдсан шалгуур үзүүлэлтүүд нь Тогтвортой хөгжлийн бодлого, түүнд тавигдсан зорилтуудыг хэрэгжүүлэх механизм, бодлого, төлөвлөлтийн нэг хэсэг нь болох юм. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар бодлогын баримт бичгийн уялдаа холбоог зохицуулсан бөгөөд УИХ-аар 2016 онд 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийг хэрэгжүүлэх нэг үндсэн баримт бичиг бол “Бүсчилсэн хөгжлийн бодлого” гэж тодорхойлсон. Бүсчилсэн хөгжил нь газарзүйн байршил, байгаль экологийн онцлог, хүн амын амьдарлын хэв шинж, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан харилцан адилгүй. Бодлогын бичиг баримтад үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийн ялгааг дараахь байдлаар ангилж үзлээ. Үүнд:

- *Хөгжингүй & Хөгжиж байгаа улсын ялгаа*
- *Үндэсний хэмжээний & Орон нутгийн түвшний ялгаа*
- *Хэрэгжилтийг үнэлэх & Дэвшүүлж буй зорилт, арга хэмжээг үнэлэх ялгаа*
- *Суурьшлийн буюу хот, хөдөөгийн ялгаа*
- *Тоон & Чанарын шалгуур үзүүлэлтийн ядгаа*

Хөгжингүй & хөгжиж байгаа улсын ялгаа. Хөгжингүй улс орны хувьд эдийн засаг, санхүүгийн харьцангуй өндөр нөөц боломж дээрээ тулгуурлан өнгөрснөө засах, залруулах үүднээс “ухраан төлөвлөх”, мөн техник технологийн хөгжил, хүний амьдарлын чанарт илүү анхаарахад чиглэсэн байдаг бол хөгжиж байгаа улс орнуудын хувьд эдийн засаг, санхүүгийн байгаа нөөц боломждоо тулгуурлан ирээдүйн хөгжлийн хандлагаа бусад асуудал, тухайлбал, Тогтвортой хөгжилтэй уялдуулахад чиглэсэн байдаг. Мөн хөгжингүй улс орнууд Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтдээ Олон улсын өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг оруулсан байдаг. Жишээ нь, ХБНГУ-ын Тогтвортой хөгжлийн шалгуурт Олон улсад хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд “хөгжиж буй орнуудаас авч буй импортыг нэмэгдүүлэх”, “ДНБ-д эзлэх тусламжийн хөрөнгийн нэмэгдүүлэх”, “Хүлэмжийн хийн ялгаруулалтын бууруулах хувь нэмэр оруулах”, эрүүл мэнд ба хоол тэжээлийн хүрээнд “Насанд хүрэгчдийн таргалалтыг бууруулах” зэрэг шалгууруудыг тодорхойлсон байна. Харин Япон Улсын Тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтэд “Байгалийн нөөц ашигласны татварыг экосистемд буцааж нөхөн төлөх”, “Хүний эрүүл, аюулгүй, аз жаргалтай амьдрах нөхцөл, нийгмийн стрессийг арилгах” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг оруулсан³.

Манай нөхцөлд Тогтвортой хөгжлийн зорилт, үзэл баримтлал дээрээ тулгуурлан Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтээ тодорхойлохдоо хөгжиж байгаа улс орны хувьд байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, байгалийн арвин нөөц баялаг, газар зүйн байршил, байгаль орчиндоо зохицон амьдрах чадвар, соёл, уламжлалын онцлог давуу байдалдаа тулгуурлан “урагшаа төлөвлөх” шаардлагатай.

Үндэсний хэмжээний & орон нутгийн түвшний ялгаа. Тухайн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт нь Үндэсний хэмжээний түвшинг үнэлэх шалгуур уу эсвэл бүс

³ Япон Улсын Тогтвортой хөгжлийн шалгуур.

http://pub.iges.or.jp/modules/envirolib/upload/3286/attach/pb_12_e_final.pdf

нутаг, орон нутгийн түвшинг үнэлэх шалгуур уу гэдгээс шалтгаалан ялгаатай. Үндэсний хэмжээний шалгуур үзүүлэлт нь тухайн улсын хөгжлийн түвшинг бүхэлд нь үнэлгэх, нэгдмэл шинж чанартай, мөн тоон статистик мэдээлэлд тулгуурлах бололцоотой байдаг бол орон нутгийн хөгжлийг үнэлэх шалгуур нь тухайн орон нутгийн газарзүйн байршил, эдийн засгийн онцлог, хэв шинжээс илүү хамаарсан, улсын хэмжээнд нэгдмэл үнэлгээ хийхэд зориулагдсан байж болно. Манай нөхцөлд аймаг, орон нутгийн бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх зорилготой.

Хэрэгжилтийг үнэлэх болон дэвшүүлж буй зорилт, арга хэмжээг үнэлэх ялгаа.

Ямар нэгэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, эсвэл дэвшүүлж буй зорилт, арга хэмжээг үнэлэх шалгуур нь тавьсан зорилго, хэрэглээний хувьд ялгаатай. Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх нь тухайн бодлого батлагдсан үеэс хойш тодорхой хугацааны дараа суурь онтой харьцуулахад зорилтод түвшинд хүрсэн эсэхийг тоон шалгуур үзүүлэлтүүдээр ихэвчлэн өнгөрсөн үеийг үнэлдэг. Жишээ нь, УИХ-аар батлагдсан Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын⁴ хэрэгжилтийг 2020, 2030 онуудад нийт 20 тоон шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн. Хэрэгжилтийг ихэвчэн үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд тулгуурлан үнэлдэг.

Харин дэвшүүлж буй зорилт, арга хэмжээг үнэлэх нь тоон шалгуур үзүүлэлт тавихаасаа илүүтэй **чанарын шалгуур үзүүлэлт** тавих байдлаар үнэлэх бололцоотой. Манай нөхцөлд судалгааны зорилготой уялдуулан тухайн орон нутгийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хүрээнд бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтэд нийцэх ямар арга хэмжээг тусгасан, мөн тусгагдаагүй орхигдсон ямар арга хэмжээ үлдсэн эсэхэд шинжилгээ хийх бололцоотой юм. Манай нөхцөлд ямар нэгэн бодлогын хэрэгжилтэд бус харин 21 аймгийн бодлого хөтөлбөрийн дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг өөрсдийн тодорхойлсон Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтээр бодлогын шинжилгээ хийх зорилготой.

Суурьшлийн буюу хот, хөдөөгийн ялгаа. Суурьшлийн буюу хот, хөдөөгийн ялгааг тооцож үзэх шаардлагатай. Хүн ам нь хотод ихээр төвлөрсөн, эдийн засгийн хувьд хотоос илүү хамаарсан улсын хувьд шалгуур үзүүлэлт нь хотоос илүү хамаарсан байж болно. Монгол Улсын хувьд суурьшлийн хот (аймгийн төв), сумын төв, хөдөө нутаг гэсэн хэлбэрүүдийг хамруулах шаардлагатай. Иймд манай нөхцөлд Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтээ тодорхойлохдоо суурьшлийн хэлбэрийг аль алиныг нь тооцох шаардлагатай.

Нөгөө талаас хөдөө орон нутагт статистик мэдээлэлийн сан болон мэргэжилтэй боловсон хүчин төдийлөн бэхжиж амжаагүй байгаа учир шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо тодорхой цөөн тоотой, эхний байдлаар даацтай мэдээлэл өгөх үүднээс **тоон шалгуур үзүүлэлтээр** хатуу үнэлэх бус харин бүсчилсэн хөгжилтэй холбоотой хийж байгаа ажил, арга хэмжээ, цаашдын зорилтуудыг бүсчилсэн хөгжилтэй холбогдуулан **чанарын хувьд шалгуур үзүүлэлт** тавих бололцоотой. Гэхдээ цаашдаа уг шалгуур үзүүлэлтийг хэрэгжилтийг үнэлэх, тоон шалгуур байдлаар баяжуулах бололцоотой.

⁴ “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”. УИХ-ын 2016 оны 19 дугаар тогтоол.

Орон нутгийн бодлогын баримт бичгийн хамрах хүрээ. Үндэсний болон орон нутгийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээ шинжилгээ хийхдээ дараахь баримт бичгийг хамруулан гүйцэтгэсэн болно. Үүнд:

Эрхзүйн баримт бичиг

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хууль
- Чөлөөт бүсийн тухай хууль
- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль

Үндэсний болон салбарын бодлогын баримт бичиг

- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030⁵
- Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал⁶
- Гурван тулгуурт хөгжлийн бодлого⁷
- Үйлдвэржилт 21:100” Үндэсний хөтөлбөр⁸
- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого⁹
- Бусад

Аймгийн түвшинд:

Хүснэгт 3. Аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр

№	Бодлогын баримт бичгийн нэр	Хамрах хүрээ	Хэрэгжих хугацаа	Баталсан шийдвэр, огноо
1	Архангай аймгийн хөгжлийн цогц бодлого 2011-2021 он	Архангай аймаг	2011-2021	Аймгийн ИТХ-ын 2011 оны 05 дугаар тогтоол
2	Баян-Өлгий аймгийн хөгжлийн хөтөлбөр	Баян-Өлгий аймаг	2010-2021	Аймгийн ИТХ-ын 2009 оны V хуралдаан
3	“Баянхонгор аймгийн ойжуулалт-20” хөтөлбөр	Баянхонгор аймаг	2000-2020	Аймгийн ИТХ-ын 2000 оны 2/6 дугаар тогтоол
4	Баянхонгор аймгийн хөгжлийн хөтөлбөр	Баянхонгор аймаг	2006-2020	
5	Булган аймгийн эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр	Булган аймаг	2006-2020	Аймгийн ИТХ-ын 2005 оны 05/07 дугаар тогтоол
6	Булган аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021 он/	Булган аймаг	2010-2021	Аймгийн ИТХ-ын 2010 оны 06/01 дугаар тогтоол
7	Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008-2021 он)	Говь-Алтай аймаг	2008-2021	
8	Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр	Говьсүмбэр аймаг	2003-2020	
9	Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого	Говьсүмбэр аймаг	2010-2021	Аймгийн ИТХ-ын 2011 оны 3 дугаар тогтоол

⁵ Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол. Улаанбаатар

⁶ Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. Улаанбаатар

⁷ Гурван тулгуурт хөгжлийн бодлого. Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоол. Улаанбаатар

⁸ Үйлдвэржилт 21:100” Үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоол. Улаанбаатар

⁹ Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого. УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоол. Улаанбаатар

10	“Сүмбэр хонь” хөтөлбөр	Говьсүмбэр аймаг	2010-2019	Аймгийн ИТХ-ын 2010 оны 61-р дүгээр тогтоол
11	Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)	Дархан-Уул аймаг	2009-2021	Аймгийн ИТХ-ын 2009 оны 05/01 дугаар тогтоол
12	Дархан-Уул аймгийн “Хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”	Дархан-Уул аймаг	2008-2021	Аймгийн ИТХ-ын 2009 оны 36 дугаар тогтоол
13	Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого	Дорноговь аймаг	2002-2020	Аймгийн ИТХ-ын 2002 оны 18 дугаар тогтоол
14	Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/	Дорноговь аймаг	2011-2021	Аймгийн ИТХ-ын 2011 оны 26 дугаар тогтоол
15	Эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө (2009-2021 он)	Дорноговь аймаг, Сайншанд сум	2009-2021	Сайншанд сумын ИТХ-ын 2009 оны 06/01 дугаар тогтоол
16	Дундговь аймгийн 2020 он хүртлэх хөгжлийн бодлого	Дундговь аймаг	2003-2020	
17	“Мандал хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөө (2009-2021 он)	Дундговь аймаг, Сайнцагаан сум	2009-2021	Сайнцагаан сумын ИТХ-ын 2009 оны 47 дугаар тогтоол
18	Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)	Завхан аймаг	2009-2021	
19	Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)	Орхон аймаг	2009-2021	
20	Оюунлиг Ховд хөгжлийн хөтөлбөр	Ховд аймаг	2009-2021	
21	“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он)	Өмнөговь аймаг	2010-2020	
22	Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөр /2007-2021 он/	Сэлэнгэ аймаг	2007-2021	
23	Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)	Төв аймаг	2008-2023	Аймгийн ИТХ-ын 2008 оны 2 дугаар тогтоол
24	Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр /2008-2021 он/	Увс аймаг	2008-2021	Аймгийн ИТХ-ын 2008 оны 08/01 дугаар тогтоол
25	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө	Улаанбаатар хот		ЗГ-ын 2002 оны 28 дугаар тогтоол
26	Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021 он)	Хэнтий аймаг	2010-2021	Аймгийн ИТХ-ын 2010 оны 04 дүгээр тогтоол
27	Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт	Дорнод аймаг	2016-2025	Аймгийн ИТХ-ын 2016 оны ... дүгээр тогтоол


Үе шат II. Чанарын “Шалгуур үзүүлэлт”-ээр аймгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх

- 1. Бүсчилсэн хөгжлийн чанарын “Шалгуур үзүүлэлт” тодорхойлох тухай.*** Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд Бүсчилсэн хөгжлийн бодлого нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой

байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг гэж заасан. Энэ агуулгаар Бүсчилсэн хөгжлийн Чанарын шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Гурван тулгуурт хөгжлийн бодлого зэрэг баримт бичиг тулгуурлан Бүсчилсэн хөгжлийн агуулга бүхий чанарын шинжилгээ “шалгуур үзүүлэлт”-ийг тодорхойлно.

2. **Шалгуур үзүүлэлтээр орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээ хийх тухай.** Бүсчилсэн хөгжлийн агуулгаар аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж байгаа хөгжлийн бодлого, хөтөлбөрийн орчинд шалгуур үзүүлэлтээр баримт бичгийн шинжилгээ хийж, дүгнэлт өгнө.

Зураг 2. Аймаг, орон нутгийн бодлого, хөтөлбөрт бодлогын анализ хийх аргазүйн схем



Дээрх судалгаа, шинжилгээний үр дүнд тулгуурлан хөгжлийн бодлогын нөлөөллийн урьдчилсан үнэлгээг “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж өгөх үүрэг бүхий Ажлын хэсэг”-тэй¹⁰ хамтран боловсруулна.

2.2. Хөгжлийн ирээдүй сайтай сум, сууринг тодорхойлох аргачлал

Бүсчилсэн хөгжлийн агуулгаар орон нутгийн хөгжлийн асуудалтай холбоотой нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх аргачлалыг энэ хэсэгт орууллаа. Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь орон нутгийн түвшинд урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх хүндрэл, бэрхшээл, асуудлыг судалж

¹⁰ Ерөнхий сайдын 2017 оны 165 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг. Улаанбаатар

тодорхойлоход оршино. Ингэхдээ хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн хөгжлийн болон байгаль орчны үндсэн үзүүлэлтүүдээр 21 айгмийн хөгжлийн өнөөгийн байдалд статистик анализ, дүн шинжилгээ хийж, орон нутгийн түвшинд тулгамдаж асуудлыг тодорхойлно. Нөхцөл байдлын шинжилгээг хийхдээ Монгол Улсын Тогвортой хөгжлийн үзэл баримтлал 2030¹¹ болон Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай¹² уялдуулан, түүнд тусгагдсан үндсэн үзүүлэлтүүдээр шинжилгээ хийж, дүгнэлт өгнө.

Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх төвлөрлийг сааруулах бодлогын өнцгөөс харж, нийгэм, эдийн засаг, байгаль орчны дараахь үзүүлэлтүүдээр бодлогын анализ хийж, график, GIS зураглалаар үзүүлнэ. Үүнд,

- Хүн ам зүй, нийгэм → хүн ам, өрхийн тоо, өсөлт, шилжилт хөдөлгөөн, хүн амын ачаалал, дундаж наслалт, хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн идвэхитэй хүн ам, ажилгүйдэл, хөдөлмөрийн бүтээмж, ядуурал, хүн амын амьжиргааны түвшин, хүний хөгжил, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ болон бусад үзүүлэлт.
- Эдийн засаг → Орон нутгийн түвшинд эдийн засгийн бодит салбаруудын өнөөгийн байдал, ДНБ, эдийн засгийн бүтэц, ДНБ-ний өсөлт, бууралт, өрхийн орлого, зарлага, сарын дундаж цалин, орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, орон нутгийн санхүүгийн дэмжлэг болон бусад үзүүлэлт.
- Байгаль орчин → Газар ашиглалт, доройтол, цөлжилт, байгалийн нөөц, түүний ашиглалт, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээр, ой, усны нөөц ашиглалт, тулгамдсан асуудал болон бусад үзүүлэлт.

Нийгэм, эдийн засаг, байгаль орчны өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгөхөд дараахь судалгааны аргыг хэрэглэнэ. Үүнд,

- Статистик шинжилгээний арга
- Газарзүйн мэдээллийн системд тулгуурласан орон зайн анализийн арга
- Хувьсагч хоорондын харилцан үйлчлэл, хамаарлын шинжилгээ хийх корреляцийн арга
- Регрессийн шинжилгээний арга

Хүн амын шилжилт хөдөлгөөн тооцох арга. Шилжилт хөдөлгөөн нь Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулахад нэг чухал хүчин зүйл болдог. Учир нь дараах 2 тохиолдолд хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн явагдаж байна. Үүнд: 1. Хөгжиж буй орны шилжилт хөдөлгөөний онолын дагуу хүн ам цөөн, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих зах зээл бага, төрийн үйлчилгээний чанар хүртээмж сул хөдөө орон нутгаас иргэд ажлын байр хайж хот руу шилжин суурьшдаг. Монгол Улсын хувьд ялангуяа сумын төвд ажлын байр нэмэгдэх боломж бага тул хөдөөгийн оюутнууд ихэнхи тохиолдолд төгссөнийхөө дараа ажил эрхлэхээр хотод суурьшин үлдсэнээр хөдөө орон нутагт хүн амын тоо буурч, зах зээлийн багтаамж багассанаар эмзэг байдал нэмэгддэг. 2. Бэлчээрийн экологийн эмзэг байдлаас буюу ган, зудад мал сүргээ ихээр алдсаны дараа малгүй болсон олон мянган хөдөөгийн иргэд өрхийн амьжиргаагаа тэтгэхийн тулд хот, суурин газрыг бараадаж шилжин суурьшдаг. Энэ үзэгдэл 1999-2001 оны дараалсан зуд, 2009-2010 оны зудын дараа

¹¹ Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол. Улаанбаатар.

¹² Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. Улаанбаатар.

хөдөөгийн малчин өрхийн тоо хэдэн мянгаар буурч, хот руу шилжин суурьшсанаас тодорхой харагддаг.

Ажилгүйдэл тооцох арга. Эдийн засгийн идэвхтэй хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно. Ажилгүйчүүд гэдэгт ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа, тухайн судалгаа авах үед болонсүүлийн 12 сард ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөридэвхтэй хайж буй хүнийг оруулдаг. Ажилгүйдлийг сумын түвшинд гарах боломжтой байгаа мэдээлэлд үндэслэн: 1) бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо; эсвэл 2) сумын нийт хөдөлмөрийн насны хүн амд эзлэх ажилгүй иргэдийн хувь хэмжээгээр тооцно.

Хот, хөдөөгийн үн амын жилийн дундаж өсөлт тооцох аргачлал: Хүн амын тоог 1996, 2006, 2017 оноор болон хүн амын өөрчлөлтийг 1990-2000, 2000-2010, 2010-2017 онуудын хоорондох хүн амын жилийн дундаж өсөлтөөр нь хүн амын өсөлт, бууралтыг улсын дундажтай харьцуулан үнэллээ.

Монгол Улс хүн амын нутагшилт, суурьшлийн хувьд өвөрмөгц онцлогтой бөгөөд Үндэсний статистикийн тооллогын тогтолцоогоор хүн амыг суурьшлийн хувьд хот ба хөдөө гэж ангилдаг. Хотын хүн амын ангилалд Нийслэл хот, 21 аймгийн төв хот болон томоохон суурин газар болох тосгон, харин хөдөөгийн хүн амын ангилалд сумын төв болон хөдөө нутагт нүүдлийн мал аж эрхлэн амьдардаг хүмүүсийг хамруулдаг.

Мөн Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн¹³ 3 дугаар болон 4 дүгээр зүйлээр Хот, тосгоныг ангилан, зэрэглэл тогтоож өгсөн. Үүнд,

- **Тосгон (Village)** → 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар
- **Аймгийн зэрэглэлтэй хот (Province ranking city)** → 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар
- **Улсын зэрэглэлтэй хот (State ranking city)** → 50000-аас дээш (шаардлагатай гэж үзвэл 50000 хүртэл) оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хотжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно

Мөн сум сууринг дотор нь 3000-аас доош хүн амтай сум суурин, 3000-8000 хүн амтай сум, суурин, 8000-аас дээш хүн амтай сум, суурин гэж ангилсан.

Улсын нийслэл, бүсийн болон аймгийн төв 22 хот болон 309 сумдын түвшинд хүн амын өөрчлөлтийг “Хүн амын жилийн дундаж өсөлт, бууралт” тооцох аргачлалаар¹⁴ 1990-2000, 2000-2010, 2010-2017 оны хооронд тооцоолсон. 1990-2017 оны хооронд Улсын хэмжээнд хүн амын жилийн дундаж өсөлт 1.95% байсан ба тухайн аймгийн төв болон сумдын хүн ам “буурсан”, “хэвийн өссөн”, “механик өсөлттэй” гэсэн үндсэн 3 нөхцөл дараахь утгыг илэрхийлнэ. Үүнд,

¹³ Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хууль. УИХ-ийн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэр. Улаанбаатар.

¹⁴ Үндэсний статистикийн хороо. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал. Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/152 тоот тушаалын хавсралт. Улаанбаатар.

- Хэрэв, < 0 **буюу** хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь нь сөрөг утгатай **бол** тухайн хугацаанд, тухайн аймгийн төв болон суманд хүн ам өсөөгүй **буюу** “буурсан”
- Хэрэв, $0 \div 1.95\%$ **буюу** хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь нь тэгээс 1990-2017 оны хооронд Улсын хэмжээнд тооцсон өсөлтийн хувь (1.95%)-ийн хооронд **бол** тухайн хугацаанд, тухайн аймгийн төв болон суманд хүн ам өссөн **буюу** “хэвийн өссөн”
- Хэрэв, $1.95\% <$ **буюу** хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь нь 1990-2017 оны хооронд Улсын хэмжээнд тооцсон өсөлтийн хувь (1.95%)-иас их **бол** тухайн хугацаанд, тухайн аймгийн төв болон суманд хүн ам илүү өссөн **буюу** “механик өсөлттэй” гэж тус тус үзнэ.

Судалгааны зорилгын дагуу гео-орон зайн анализ хийх үүднээс дээрх 3 улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдан хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төмөр зам, авто замтай холбоотой, бүтээн байгуулалтын шинжтэй 9 төсөл (коридор)-ийн эхлэл болон төгсгөлийн цэгийн хотын нэр, маршрутын агуулга нэр, түүний дайран өнгөрч буй тухайн улсын бүс, хот, тосгон, хилийн болон далайн боомтыг тухайн хөтөлбөрт тусгагдсан нэршилээр нь Газарзүйн мэдээллийн систем (GIS)-д зураглал хийн оруулсан болно. Ингэж GIS-д бэлтгэн оруулснаар тухайн коридорын дагуух бүс нутаг, аймаг, хот, сум, тосгодын нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг эдийн засгийн коридортой уялдуулан орон зайн анализ хийж, дүгнэлт өгөхөд оршино.

Хөгжил, байршлын зураглал хийх арга. Судалгаанд нийгэм, эдийн заса, байгаль орчны холбогдох мэдээллийг Газарзүйн мэдээллийн систем (GIS)-д оруулан орон зайн анализ хийж, дүгнэлт өгнө. Судалгааны хүрээнд дараахь программ хангамжийг ашиглана.

- ArcGIS 9.2 → Нийгэм, эдийн засаг, байгаль орчин болон дэд бүтцийн байгууламжийн цаг хугацаа, орон зайн цогц мэдээллийн сан үүсгэж, судалгаанд ашиглах, системийн динамик судалгаа, дүн шинжилгээ, зураглал-төлөвлөлт хийнэ;
- ILWIS3.3 → Сансрын мэдээнд дүн шинжилгээ хийх, дүрс боловсруулалт, судалгаанд үндэслэн байгаль орчны төлөвлөлт, нөөцийн менежмент хийхэд ашиглана.

ГУРАВ. БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

3.1. Бүсчилсэн хөгжлийн чанарын шалгуур үзүүлэлт

Үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт Бүсчилсэн хөгжлийн агуулгаар тодорхойлсон чанарын шалгуур үзүүлэлтээр бодлогын шинжилгээ хийлээ. Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг хэрхэн тодорхойлсон, шалгуур үзүүлэлтээр хэрхэн бодлогын шинжилгээ хийх тухай мэдээллийг аргазүй, аргачлалын хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

УИХ, Засгийн газраас баталсан Үндэсний хэмжээний 15 бодлого, хөтөлбөр болон 21 аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт Бүсчилсэн хөгжлийн агуулгаар бодлогын шинжилгээ хийх шалгуур үзүүлэлтийг дараахь хүснэгтээс харна уу.

Хүснэгт 4. Бүсчилсэн хөгжлийн агуулгаар Үндэсний, салбарын болон орон нутгийн хөгжлийн баримт бичигт бодлогын шинжилгээ хийх “Шалгуур үзүүлэлт”

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн үндэслэл, холбоотой бодлого, хөтөлбөрийн зорилт	Шалгуур үзүүлэлтээр бодлогын шинжилгээ хийх баримт бичиг	
			Үндэсний болон бүс нутгийн түвшинд	Орон нутгийн түвшинд
1	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ тогтоож, өөр хоорондоо хоршин хөгжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.2, 4.7.1.е, 4.7.1.ж - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 4		21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
2	Бүсийн түвшинд өөр хоорондоо хоршин хөгжих бизнесийн орчныг бүрдүүлэх, дэмжих, дотоод, гадаад зах зээлтэй холбох зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.2, 4.7.2.г, 4.7.2.д, 3.14 - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 2		21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
3	Хүн ам тухайн нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, шилжилт хөдөлгөөнийг бууруулах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.2 - Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого	- Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого ¹⁵ - Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого ¹⁶	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
4	Бүсийн хүрээнд байгалийн баялгийн нөөц ашигласны эцсийн үр өгөөжийг тухайн бүсийн аймаг, сумд адил тэнцүү хүртэх орлого хуваарилалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.4, 4.7.3.е - НҮБ-ын ТХЗ-ын 10 -	- Ногоон хөгжлийн бодлого ¹⁷	
5	Бүсүүдэд их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны төв (ШУТПарк, R&D, инноваци г.м)-үүдийг байгуулахыг дэмжих, тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга	- БХҮБ-ын 4.7.4.а. - НҮБ-ын ТХЗ-ын 4 - ТХҮБ 2030-ын 2.1.3-ын зорилт 4, 5	- Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого ¹⁸ - Төрөөс шинжлэх ухаан, технологийн	

¹⁵ Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоол. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр. Улаанбаатар.

¹⁶ Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоол. Ноолуур хөтөлбөр (2018-2021). Улаанбаатар.

¹⁷ УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.

¹⁸ Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоол. Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого. Улаанбаатар.

	хэмжээ		талаар баримтлах бодлого ¹⁹ - Судалгаанд суурилсан их их сургуулийг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр ²⁰	
6	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулах, сум дундын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.б. - НҮБ-ын ТХЗ-ын 3 - ТХҮБ 2030-ын 2.2.2-ын зорилт 1	-	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
7	Бүс нутгийн хэмжээнд хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бий болгох бүс нутаг-хотжилтын нэгдмэл орчныг бий болгох зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.5 - НҮБ-ын ТХЗ-ын 11 - ТХҮБ 2030-ын 2.1.5-ын зорилт 5, 6	-	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
8	Эдийн засаг, тээврийн коридорын дагуух бүс нутгуудыг олон улсын худалдаа-эдийн засгийн сүлжээнд зохистой холбож, гадаад харилцааны боломжийг бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг хангах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.6 - НҮБ-ын ТХЗ-ын 17 -	- МУ-ын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр ²¹ - Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр - Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр ²² - “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр ²³	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
9	Бүс нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай	- БХҮБ-ын 3.2.1, 3.2.2 -	- Монгол улсын засгийн газрын 2016-	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт

¹⁹ Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.

²⁰ УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол. Ногоон хөгжлийн бодлого. Улаанбаатар

²¹ Засгийн газрын 2015 оны 474 дүгээр тогтоол. МУ-ын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр. Улаанбаатар.

²² УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Улаанбаатар.

²³ Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоол. “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр. Улаанбаатар.

	бодлого явуулах зорилт, арга хэмжээ		2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр ²⁴	(бодлого, хөтөлбөр)
10	Бүсийн онцлог, давуу талд тулгуурлан төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн харилцан адилгүй, явгавартай бодлогоор дэмжих зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.в, 4.7.1.г. - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 4	- Төсвийн тухай хууль - Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр ²⁵	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
11	Бүс нутгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих, татах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.д	- Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр ²⁶	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
12	Үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот, сум сууринг тодорхойлох, тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлж	- БХҮБ-ын 3.5, 3.8 -	- Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр ²⁷ -	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
13	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.е, 4.7.1.ж -	-	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
14	Бүсийн түвшинд салбар болон бизнес эрхлэгч хоорондын аж ахуйн хоршилт, хослолыг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.г, 4.7.2.д, 3.14 - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 2 - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 4	- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого ²⁸	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
15	Бүс нутаг, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.з.	-	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
16	Бүс нутгийн түвшинд орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн чадавхийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэлийн сүлжээг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.а.	-	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)

²⁴ УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Улаанбаатар.

²⁵ Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр. Улаанбаатар.

²⁶ Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр. Улаанбаатар.

²⁸ УИХ-ийн 2015 оны 62 дугаар тогтоол. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.

17	Гадаад, дотоод хэрэгцээг харгалзан бүсийн түвшинд импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.б. - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 2	- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого ²⁹	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
18	Бүсийн түвшинд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулах буюу өөрийн салбар, нэгжээ байгуулж ажиллахыг хөхүүлэн дэмжих зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.е. - -		21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
19	Бүсийн түвшинд хүн амын ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүс, аймаг, сум дундын санхүүгийн механизм бий болгох	- БХҮБ-ын 4.7.4.д. - НҮБ-ын ТХЗ-ын 1 - ТХҮБ 2030-ын 2.2.1-ын зорилт 1, 2	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого ³⁰	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
20	Хил орчмын болон алслагдсан бүс нутагт ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтыг татах, урамшуулах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.д.		21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
21	Бүсийн түвшинд аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж зорилт, арга хэмжээ	- ТХҮБ 2030-ын 2.1.3-ын зорилт 1	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого ³¹	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
22	Бүсийн хэмжээнд ХАА болон үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилт, арга хэмжээ			21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
23	Бүс нутгийн өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл-кластер хөгжүүлэх зорилт, арга хэмжээ			21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
24	Бүсийн түвшинд боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ			21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
25	Бүсийн түвшинд аялал жуулчлалыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хөгжүүлэх	- ТХҮБ 2030-ын 2.1.2-ын зорилт 1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт

²⁹ УИХ-ийн 2015 оны 62 дугаар тогтоол. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.

³⁰ Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.

³¹ УИХ-ийн 2015 оны 62 дугаар тогтоол. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.

	зорилт, арга хэмжээ		үндэсний хөтөлбөр ³²	(бодлого, хөтөлбөр)
26	Бүсийн түвшинд зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- ТХҮБ 2030-ын 2.1.5-ын зорилт 3	“Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр ³³	21 аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)

Боловсруулсан: М.Алтанбагана, 2018. Бүсчилсэн хөгжлийн чанарын шалгуур үзүүлэлт

3.2. Шалгуур үзүүлэлтээр аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээ хийсэн байдал

Бүсчилсэн хөгжлийн чанарын “Шалгуур үзүүлэлт”-ийг өмнөх хүснэгтэд харуулсан. Уг шалгуур үзүүлэлтээр аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт хэрхэн бодлогын шинжилгээ хийх аргачлал, зарчмын талаар аргагүйн хэсгээс үзнэ үү.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд Бүсчилсэн хөгжлийн бодлого нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг гэж заасан.

Энэ агуулгаар Бүсчилсэн хөгжлийн Чанарын шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Гурван тулгуурт хөгжлийн бодлого зэрэг баримт бичиг тулгуурлан Бүсчилсэн хөгжлийн агуулга бүхий чанарын шинжилгээ “шалгуур үзүүлэлт”-ийг тодорхойлсон болно.


Бүсчилсэн хөгжлийн агуулгаар боловсруулсан 26 чанарын шалгуур үзүүлэлтээр аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж байгаа хөгжлийн бодлого, хөтөлбөрийн орчинд бодлогын шинжилгээ хийж, энэ хэсэгт харууллаа.

Монгол Улсын хэмжээнд нийт 21 аймгийн (нийслэл УБ болон Ховд, Сүхбаатар аймгуудын хөгжлийн бодлого байхгүй) дунд, богино хугацааны бодлого төлөвлөлтөнд нийт 1175 стратегийн зорилт, 7983 дэд зорилт, арга хэмжээг дэвшүүлж гаргасан байна. Стратегийн зорилтын 28.60% нь хүний болон нийгмийн хөгжил, 50.64% нь эдийн засгийн өсөлт, 15.23% нь байгаль орчин, 5.53% нь нутгийн удирдлага, нийгмийн оролцоо гэсэн хүрээнд хамарч байна. Харин дэд зорилтын 30.64% нь хүний болон нийгмийн хөгжил, 48.92% нь эдийн засгийн өсөлт, 13.35% нь байгаль орчин, 7.09% нь нутгийн удирдлага, нийгмийн оролцоо гэсэн хүрээг хамарч байна (Зураг 3).

Зураг 3. Аймаг, орон нутгийн бодлого, хөтөлбөрийн стратегийн зорилт, дэд зорилт

³² Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоол. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр. Улаанбаатар.

³³ Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоол. “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр. Улаанбаатар.



Хүснэгт 5. Аймгуудын хөгжлийн хөтөлбөрийн зорилт, дэд зорилтууд (салбарын бодлогоор)

№	Аймаг	Аймгийн хөгжлийн хөтөлбөрийн нэр	Хүний болон нийгмийн хөгжлийн бодлого		Эдийн засгийн өсөлт, хөгжлийн бодлого		Байгаль орчны бодлого		Нутгийн удирдлага, нийгмийн оролцоо, түншлэлийг хангах бодлого		Нийт	
			Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт
1	Архангай	Архангай аймгийн хөгжлийн цогц бодлого 2011-2021	18	95	25	168	6	31	4	37	53	331
2	Баян-Өлгий	Баян-Өлгий аймгийн хөгжлийн хөтөлбөр 2010-2021	17	159	22	171	5	46	1	79	45	455
3	Баянхонгор	Баянхонгор аймгийн хөгжлийн хөтөлбөр 2006-2020	16	188	47	314	16	83	4	71	83	656
4	Булган	Булган аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021 он/	26	194	28	266	6	60	4	52	64	572
5	Говь-Алтай	Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого 2008-2021	17	120	27	193	6	53	0	0	50	366
6	Говьсүмбэр	Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)	20	212	27	174	5	39	4	29	56	454
7	Дархан-Уул	Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого 2009-2021	17	126	54	270	6	78	0	0	77	474
8	Дорноговь	Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө 2011-2021	27	124	72	371	7	73	9	56	115	624
9	Дорнод	Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2016-2025	16	149	22	199	0	0	0	0	38	348

10	Дундговь	Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого	26	194	18	180	1	17	0	0	45	391
11	Завхан	Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого 2009-2021	17	141	28	195	6	59	0	0	51	395
12	Орхон	Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)	13	45	26	106	3	28	4	19	46	198
13	Өвөрхангай	Өвөрхангай аймгийн хөгжлийн цогц бодлого-2007-2015	4	84	10	120	7	45	1	14	22	263
14	Өмнөговь	“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он)	17	134	28	135	50	67	0	0	95	336
16	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөр 2007-2021			54	370	16	120	8	56	78	546
17	Төв	Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023)	15	91	30	197	19	130	6	29	70	447
18	Увс	Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр 2008-2021	26	135	33	211	6	43	20	124	85	513
19	Ховд	Оюунлаг Ховд хөгжлийн хөтөлбөр										
20	Хөвсгөл	Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг 2008-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр	27	95	17	68	8	48	0	0	52	211
21	Хэнтий	Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021 он)	17	160	27	197	6	46	0	0	50	403

Жич: Аймаг, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг хүснэгт 5-аас харж болох бөгөөд Сүхбаатар болон Ховд аймгуудын хөгжлийн хөтөлбөрийн бодлого байхгүй буюу Өвөрхангай болон Хөвсгөл аймгуудын хөгжлийн хөтөлбөрийн хугацаа дууссан байна.

Дараахь хүснэгтэд Бүсчилсэн хөгжлийн 26 чанарын шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа аймгуудын хөгжлийн бодлого, хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээг тоогоор шалгуур үзүүлэлт бүрээр харууллаа. Тухайлбал, Дорнод аймаг Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа нийт 58 зорилт, арга хэмжээг аймгийн 2025 он хүртэлх хөгжлийн хэтийн зорилтод дэвшүүлсэн бөгөөд үүнээс 14 нь Шалгуур-1 буюу “Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ тогтоож өөр хоорондоо хоршин хөгжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ”-тэй, мөн 1 зорилт, арга хэмжээг шалгуур-2 буюу “Бүсийн түвшинд өөр хоорондоо хоршин хөгжих бизнесийн орчныг бүрдүүлэх, дэмжих, дотоод, гадаад зах зээлтэй холбох зорилт, арга хэмжээ”-тэй тус бүр нийцсэн зорилтыг дэвшүүлжээ.

Хүснэгт 6. Аймгуудын хөгжлийн хөтөлбөрт Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлт тус бүрт нийцэж байгаа зорилт, арга хэмжээ, тоо

№	Шалгуур үзүүлэлт	Дорнод	Хэнтий	Архангай	Баянхонгор	Булган	Орхон	Өвөрхангай	Хөвсгөл	Увс	Говь-Алтай	Баян-Өлгий	Завхан	Дорноговь ³⁴	Говьсүмбэр ³⁵	Дархан-Уул ³⁶	Дундговь	Сэлэнгэ (нийгмийн бодлого байхгүй)	Төв	Өмнөговь
1	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ тогтоож өөр хоорондоо хоршин хөгжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	14	4	0	1	0	1	1	0	1	0	0	0	2	2	3	2	1	3	1
2	Бүсийн түвшинд өөр хоорондоо хоршин хөгжих бизнесийн орчныг бүрдүүлэх, дэмжих, дотоод, гадаад зах зээлтэй холбох зорилт, арга хэмжээ	1	0	0	1	0	0	0	0	5	2	0	2	0	0	1	0	0	1	0
3	Хүн ам тухайн нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, шилжилт	6	2	1	0	0	0	1	0	0	2	3	2	0	3	0	2	1	2	2

³⁴ Бодлогын шинжилгээнд Дорноговь аймгийн хувьд 2 баримт бичгийг хамруулсан. Үүнд, 1. Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого /хөтөлбөр/. 2. Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө (2011-2021)

³⁵ Бодлогын шинжилгээнд Говьсүмбэр аймгийн хувьд 2 баримт бичгийг хамруулсан. Үүнд, 1. Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой Хөгжлийн хөтөлбөр. 2. Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)

³⁶ Бодлогын шинжилгээнд Дархан-Уул аймгийн хувьд 2 баримт бичгийг хамруулсан. Үүнд, 1. Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он). 2. Дархан-Уул аймгийн “хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”

	хөдөлгөөнийг бууруулах зорилт, арга хэмжээ																			
4	Бүсийн хүрээнд байгалийн баялгийн нөөц ашигласны эцсийн үр өгөөжийг тухайн бүсийн аймаг, сумд адил тэнцүү хүртэх орлого хуваарилалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	1	0	0	1	0	0	0	1	2	0	6	3	0	0	0	0	3	0	1
5	Бүсүүдэд их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны төв (ШУТПарк, R&D, инноваци г.м)-үүдийг байгуулахыг дэмжих, тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	2	5	1	1	1	1	0	0	4	3	2	2	2	2	6	1	1	1	3
6	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулах, сум дундын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээ	2	1	0	1	1	4	2	3	2	3	3	2	3	5	4	3	0	1	3
7	Бүс нутгийн хэмжээнд хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бий болгох бүс нутаг- хотжилтын нэгдмэл орчныг бий болгох зорилт, арга хэмжээ	1	0	1	1	0	0	1	0	0	1	1	1	1	1	0	4	3	1	1
8	Эдийн засаг, тээврийн коридорын дагуух бүс нутгуудыг олон улсын худалдаа-эдийн засгийн сүлжээнд зохистой холбож, гадаад харилцааны боломжийг бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг хангах зорилт, арга хэмжээ	2	0	1	1	0	1	1	0	7	0	1	0	0	0	0	0	0	0	0
9	Бүс нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах зорилт, арга хэмжээ	0	0	0	0	0	1	1	1	0	0	0	0	1	0	0	0	0	0	0
10	Бүсийн онцлог, давуу талд тулгуурлан төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн харилцан адилгүй, явгавартай бодлогоор дэмжих зорилт, арга хэмжээ	0	0	0	0	0	0	0	2	0	1	0	1	1	0	0	1	0	0	1

11	Бүс нутгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих, татах зорилт, арга хэмжээ	4	1	0	1	0	1	0	0	0	0	2	3	2	2	4	4	5	2	5	0
12	Үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот, сум сууринг тодорхойлох, тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлж	0	0	1	0	3	0	0	1	1	1	0	0	2	0	0	2	3	2	1	
13	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	2	2	1	0	0	0	0	1	0	1	1	0	2	1	2	1	0	0	0	
14	Бүсийн түвшинд салбар болон бизнес эрхлэгч хоорондын аж ахуйн хоршилт, хослолыг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	1	2	0	1	1	1	0	0	0	0	4	0	2	3	2	3	2	1	1	
15	Бүс нутаг, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	0	0	0	0	0	1	0	0	0	1	1	1	0	1	3	0	1	0	0	
16	Бүс нутгийн түвшинд орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн чадавхийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэлийн сүлжээг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээ	0	0	1	0	0	1	1	1	1	4	4	3	0	0	1	0	1	3	1	
17	Гадаад, дотоод хэрэгцээг харгалзан бүсийн түвшинд импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	2	2	0	1	1	0	0	0	4	0	1	0	2	12	2	0	0	1	0	
18	Бүсийн түвшинд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулах буюу өөрийн салбар, нэгжээ байгуулж ажиллахыг хөхүүлэн дэмжих зорилт, арга хэмжээ	0	0	1	1	0	1	1	0	0	0	3	1	0	0	0	1	0	0	0	
19	Бүсийн түвшинд хүн амын ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүс, аймаг, сум дундын санхүүгийн	2	2	0	1	0	0	0	0	0	2	1	3	1	6	8	0	1	1	1	


	механизм бий болгох																			
20	Хил орчмын болон алслагдсан бүс нутагт ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтыг татах, урамшуулах зорилт, арга хэмжээ	1	1	0	0	1	0	0	1	1	1	2	0	1	0	0	0	2	0	0
21	Бүсийн түвшинд аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	1	3	1	0	1	0	0	0	4	3	2	3	4	3	7	3	5	3	1
22	Бүсийн хэмжээнд ХАА-н болон үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилт, арга хэмжээ	0	3	0	0	0	1	0	0	1	2	1	2	2	2	7	1	1	1	3
23	Бүс нутгийн өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл-кластер хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	1	0	0	0	0	0	0	1	0	1	1	2	1	1	1	0	1	0	0
24	Бүсийн түвшинд боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	3	2	0	1	1	1	0	1	0	2	7	1	4	10	3	1	5	0	1
25	Бүсийн түвшинд аялал жуулчлалыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	4	6	6	4	1	1	1	1	8	7	7	4	3	4	6	3	3	5	3
26	Бүсийн түвшинд зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	8	5	1	1	1	1	1	0	6	8	14	8	10	6	3	7	7	9	4
	Нийт зорилт, арга хэмжээ, тоогоор	58	41	16	18	12	17	11	14	47	47	68	43	46	66	63	4 0	43	40	28

Аймгуудын хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан бүсчилсэн хөгжлийн шалгуурт нийцэж байгаа болон орхигдож байгаа зорилт, арга хэмжээнүүдийг аймаг тус бүрээр тооцон гаргаж графикаар харуулж байна. Дархан-Уул, Дорнод, Архангай, Увс аймгуудын хөгжлийн бодлого хөтөлбөрт тусгагдаагүй шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж давхцуулалгүйгээр шалгуур үзүүлэлт тус бүрийн агуулгыг харууллаа.

Архангай аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд:

- Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ.
- Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын жишиг аймаг болоход чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг бүх талаар дэмжиж, хөгжлийн таатай орчныг бүрдүүлснээр дэлхийн болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлнэ.
- Аймаг, сумын төв, багуудыг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.
- Аялал жуулчлал болон хөдөө аж ахуйн салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарууд болгон хөгжүүлнэ.
- Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бий болгон экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

Зураг 4. Архангай аймгийн хөгжлийн цогц бодлого
2011-2021 он



Архангай аймгийн хувьд Бүсчилсэн хөгжлийн нийт 26 чанарын шалгуур үзүүлэлтээс 11-д нь нийцсэн зорилт, арга хэмжээг дэвшүүлсэн, харин 15 шалгуур үзүүлэлтэд нийцсэн бодлогын зорилт, арга хэмжээг бодлого, хөтөлбөрт тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, Бүсчилсэн хөгжлийн нийт 26 чанарын шалгуур үзүүлэлтээс 1, 2, 4, 6, 9, 10, 11, 14, 15, 17, 19, 20, 22-24 дахь шалгуур үзүүлэлтэд ямар нэгэн байдлаар нийцсэн хөгжлийн зорилтуудыг дэвшүүлээгүй, орхигдуулсан байна. Тухайлбал, Шалгуур 1, 11, 20 дахийг дор харууллаа.

- **Шалгуур 1:** Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ тогтоож, өөр хоорондоо хоршин хөгжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ
- **Шалгуур 11:** Бүс нутгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих, татах зорилт, арга хэмжээ

- **Шалгуур 24:** Бүсийн түвшинд боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ

Харин Бүсчилсэн хөгжлийн нийт 26 чанарын шалгуур үзүүлэлтээс 3, 5, 7, 8, 12, 13, 16, 18, 21, 25, 26-д нийцсэн чиглэлд бодлого, төлөвлөлтийн тодорхой арга хэмжээг тусгасан байна. Тухайлбал, Шалгуур үзүүлэлт-5-д нийцсэн 1 зорилт, арга хэмжээг дэвшүүлсэн бөгөөд тэр нь “Бусад аймаг, нийслэлд байгуулагдах үйлдвэрлэл, технологийн болон шинжлэх ухааны паркуудтай нягт хамтран ажиллах, уг паркуудын зарим салбаруудыг Архангайд байгуулах” гэсэн зорилт байна.

Шалгуур үзүүлэлт 3: Бүсүүдэд их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны төв (ШУТПарк, R&D, инноваци г.м)-үүдийг байгуулахыг дэмжих, тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй үялдсан сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ




Зорилт, арга хэмжээ: Бусад аймаг, нийслэлд байгуулагдах үйлдвэрлэл, технологийн болон шинжлэх ухааны паркуудтай нягт хамтран ажиллах, уг паркуудын зарим салбаруудыг Архангайд байгуулах

Ингээд бусад аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт шалгуур үзүүлэлтээр бодлогын шинжилгээ хийсэн үр дүн болон графикуудыг харууллаа.

Зураг 5. Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008-2021 он)




Зураг 6. Баянхонгор аймгийн хөгжлийн хөтөлбөр (2006-2020)




Зураг 7. Баян-Өлгий аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2021)



Зураг 8. Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)
Дархан-Уул аймгийн “Хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”



Зураг 9. Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (2003-2020)
Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)




Зураг 10. Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого (2002-2020)
Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/



Дорнод аймаг нь “Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2016-2025” бодлого, хөтөлбөртөө 2016 онд баталсан. Бодлого, хөтөлбөрийн хүрээнд Шалгуур үзүүлэлт-8-тэй нийцсэн дараах 2 бодлогын зорилт, арга хэмжээг дэвшүүлжээ. Үүнд:


- 18.14 БНХАУ-ын зүүн хойд гурван муж болох Хар Мөрөн, Жилин, Ляонин муж болон бусад хот, мужтай найрсаг харилцаа тогтоож, улс төр, эдийн засаг, худалдаа, боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, хөдөө аж ахуй, дэд бүтэц, эрчим хүч зэрэг салбарт хамтран ажиллана.
- 18.20 “Их Түмэн санаачилга”-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Зүүн Хойд Азийн улс орнуудтай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн, үр ашигтай хамтран ажиллана.

Зураг 11. Дорнод аймгийн хөгжлийн хэтийн зорилт (2016-2025)




Дорнод аймгийн хувьд нийт 26 шалгуур үзүүлэлтээс 19 шалгуурт нийцсэн бодлогын зорилт, арга хэмжээг тусгасан, харин 7 шалгуурт нийцсэн ямар нэгэн бодлого, арга хэмжээг төлөвлөөгүй буюу энэ чиглэлд төлөвлөлт хийх шаардлагатай байна.


Зураг 12. Дундговь аймгийн 2020 он хүртлэх хөгжлийн бодлого




Зураг 13. Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)




Зураг 14. Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)




Зураг 15. “Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он)




Зураг 16. Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөр /2007-2021 он/




Зураг 17. Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр (2008-2023 он)



Зураг 18. Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр /2008-2021 он/



Зураг 19. Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021 он)



3.3. Шалгуур үзүүлэлтээр Үндэсний түвшний зарим бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээ хийсэн байдал

Бүсчилсэн хөгжлийн агуулгаар боловсруулсан чанарын 26 шалгуур үзүүлэлтээр Үндэсний хэмжээнд хэрэгжихээр батлагдсан зарим бодлого, хөтөлбөрт мөн бодлогын шинжилгээ хийсэн. Ингэж бодлогын шинжилгээ хийх нь цаашид Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулахад салбарын бодлого, хөтөлбөрийн бүс нутгийн хөгжлийн асуудалтай хэрхэн уялдуулах чиглэлд анхаарах үүднээс хийлээ.

Хүснэгт 7. Үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөр

№	Үндэсний бодлого хөтөлбөр	Тогтоол шийдвэр
1	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого	Монгол Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоол
2	Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого	Засгийн газрын 2018 оны 233 дугаар тогтоол
3	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоол
4	Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого	Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоол
5	Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2018 оны 282 дугаар тогтоол
6	Ноолуур хөтөлбөр	Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоол
7	Ногоон хөгжлийн бодлого	Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоол
8	Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр	Засгийн газрын 2015 оны 474 дүгээр тогтоол
9	Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол
10	Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол
11	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого	Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол
12	“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоол
13	“Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоол
14	“Аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоол
15	Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого	Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоол


Шинжлэх ухаан технологийн салбарыг жишээ болгон оруулаа. Бүсчилсэн хөгжлийн 26 чанарын шалгуур үзүүлэлтээр шинжлэх ухаан, технологийн салбартай холбоотой шалгуур нь “Шалгуур үзүүлэлт 5: Бүсүүдэд их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны төв (ШУТПарк, R&D, инноваци г.м)-үүдийг байгуулахыг дэмжих, тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ” юм.

Шалгуур үзүүлэлт 5 салбарын бодлого хөтөлбөрт хэрхэн тусгагдсныг харуулах зорилгоор 3 салбарын бодлого хөтөлбөрийг сонгон бодлогын шинжилгээ хийсэн. Үүнд:

1. Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого.

Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоол:

- судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, дэвшилтэт технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны парк байгуулах, технологи дамжуулах төв, гарааны компани, инкубатор байгуулж, технологи бойжуулах, туршин нэвтрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;




2. Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого. Үндэсний хөтөлбөр
Засгийн газрын 2018 оны 233 дугаар тогтоол.

- их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд судалгаа боловсруулалтын ажил, дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, нэвтрүүлэх, нутагшуулах зорилгоор дотоод, гадаадын хандив, тусламж, хөрөнгө оруулалт авах, захиран зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх




3. Судалгаанд суурилсан их их сургуулийг хөгжүүлэх хөтөлбөр. Засгийн газрын 2018 оны 282 дугаар тогтоол


- Судалгаанд суурилсан их сургуулийн инновацийн дэд бүтцийн нэгж (технологи дамжуулах төв, инкубатор, дундын оффис, шинжлэх ухаан, инновацийн парк гэх мэт) байгуулахыг дэмжих.




Зураг 24. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого




Зураг 25. Ноолуур хөтөлбөр




Зураг 26. Ногоон хөгжлийн бодлого







Зураг 30. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр



Зураг 31. “Аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр



Зураг 32. “Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөр





ДӨРӨВ. ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН ОРОН ЗАЙН АНАЛИЗ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГЛАЛ

Монгол Улс Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Нийслэл Улаанбаатар хот, 21 аймагт, Нийслэл нь нийт 9 дүүрэгт, аймаг нь нийт 330 сумын нутаг дэвсгэрт хуваагддаг.

2001 онд УИХ-ын 57 дугаар тогтоолоор “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан. Уг үзэл баримтлалын эрхэм зорилго нь Монгол Улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

2001 онд УИХ-аар батлагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол Улсын нутаг дэвсгэр эдийн засгийн 5 бүсэд хуваагдахаар тогтоосон бөгөөд энэ нь эдийн засгийн хувьд бүсчилж өгсөн хил хязгаар болно. Хэдийгээр эдийн засгийн бүс нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хатуу хил хязгаар биш боловч өөртөө нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор үндэсний хэмжээнд, бүс нутгийн хөгжлийг түргэтгэх, тодорхой нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах шаардлагыг харгалзан тогтоосон нутаг дэвсгэр, зааг хүрээг хүрээг агуулна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол үзэл санаа нь Монгол Улсад эдийн засгийн бүсчлэл тогтоож, түүгээр дамжуулан бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийн нэгдмэл болон харьцангуй бие даасан тогтолцоонд суурилсан бүс нутгийн эдийн засаг, нийгмийн цогцолборуудыг бүрдүүлэх явдал юм.

Монгол Улсад эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлэхээр

заасан. Эдийн засгийн бүс бүрд хамаарах аймгуудын ерөнхий хуваарийг дараахь байдлаар тогтоож, хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан уг хуваарийг уян хатан өөрчилж байхаар тогтоосон. Эдгээр эдийн засгийн бүс бүрт тухайн бүсийн нийгэм, эдийн засгийн томоохон төвлөрөл бий болгох тулгуур төв тус бүр 2 хот, нийт 8 хот байхаар заасан.



Хүснэгт 9. Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн тогтолцоо, хамрах аймаг, тулгуур төв хот^{37,38}

№	Эдийн засгийн бүс	Эдийн засгийн бүсэд хамрагдах аймаг	Эдийн засгийн бүсийн тулгуур төв хот
1	Баруун бүс	Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд	Ховд хот, Улиастай хот
2	Хангайн бүс	Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл	Хар-хорин хот, Эрдэнэт хот
3	Төвийн бүс	Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв	Зуунмод хот, Дархан хот
4	Зүүн бүс	Дорнод, Сүхбаатар, Хэнтий	Чойбалсан хот, Өндөрхаан хот
5	Улаанбаатар бүс	Улаанбаатар хот	Улсын Нийслэл

2000 оны эхэн үед УИХ, Засгийн газраас батлагдсан гарсан Бүсчилсэн хөгжлийн асуудалтай холбоотой бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хугацаа 2015 оноор тасалбар болон дууссан. Эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, улмаар хэрэгжилт хангалтгүй байсан учир шалтгааныг тодорхойлох шаардлага байна.

³⁷ Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. Улаанбаатар.

³⁸ Бүсийн тулгуур төв хот тогтоох тухай. УИХ-ын 2003 оны 01 дугаар тогтоол. Улаанбаатар.

4.1. Хөгжлийн ирээдүй сайтай сум сууринг тодорхойлох шалгуур үзүүлэлт

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг хангах үндсэн арга зам нь Монгол Улсад эдийн засгийн бүсчлэл тогтоож, түүгээр дамжуулан бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийн нэгдмэл болон харьцангуй бие даасан тогтолцоонд суурилсан бүс нутгийн эдийн засаг, нийгмийн цогцолборуудыг бүрдүүлэх явдал мөн.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Хөгжлийн ирээдүй сайтай сум суурин, төвүүдийг хөгжүүлэхтэй холбоотой дараахь зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд,

- 3.5. Бүсүүдийн хүрээнд эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог бүрдүүлэхдээ, алслагдсан, говийн түүнчлэн сул хөгжилтэй бүс нутгийн хөгжлийг дэмжихийн хамт бүс нутгийн аж ахуйн бие даасан байдал, **үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот сууринг тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлж, түүнд ойр байгаа бусад нутгийг татан оролцуулах** чиглэл баримтална.
- 3.6. Эдийн засгийн бүсүүдийн хуваарийг тогтоохдоо, нэгдүгээрт: аймаг, орон нутгийн хүн амын аж байдлын түвшний ялгаа, түүнийг жигдрүүлэх асуудлыг тухайн бүсийн хүрээнд шийдвэрлэх дотоод, гадаад зах зээлийн болон төрийн зохицуулалтын боломж, газар, түүний баялгийг хамгаалах, ашиглах эзэмших зохимжит чиг хандлага зэргийг бодолцсон нийгэм, экологийн хүчин зүйлсийн; хоёрдугаарт: аймаг, сум, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын хоршил холбоонд түшиглэн тухайн бүсийн хүн амын хэрэгцээг хангах, байгаль орчныг хамгаалах шаардлагад зохицсон үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой бүтэц бүхий дотоод, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай нэг буюу хэд хэдэн бүтээгдэхүүнээр улсын хэмжээнд төрөлжсөн, бүс нутгийн аж ахуйн бие даасан цогцолборууд бүрдэх ирээдүйн төлөвийг баримжаалсан эдийн засаг, зах зээлийн хүчин зүйлсийн; гуравдугаарт: хот, тосгоны зэрэглэл тогтоон, тэдгээрийн дотроос хөдөөгийн хүн амын амьдралыг бүс нутгийн дотоод, гадаад орчинтой дэд бүтцийн сүлжээгээр зохистой холбон зохион байгуулах боломжтой, **ирээдүй сайтай байршсан хот, тосгоныг бүсийн, сум дундын буюу бүлэг суурингийн төв болгон сонгон хөгжүүлэх нөхцөлийг харгалзсан дэд бүтэц, хот байгуулалтын хүчин зүйлсийн аргуудыг хослон хэрэглэнэ.**
- Дэд бүтцийн хэвтээ, босоо тэнхлэгүүдийг нутаг дэвсгэрийн болон салбарын дараахь бүрдэл хэсгүүдтэй байхаар зохион байгуулахыг зохистой гэж үзээд, 3.8.1-д хэвтээ тэнхлэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот, тосгон, бүсийн төвүүд, худалдаа-эдийн засгийн чөлөөт бүсүүд, ашигт малтмал олборлолт, боловсруулалтын болон аялал жуулчлалын бүс нутгууд, **түргэн хөгжих ирээдүйтэй бусад бүс нутаг, тэдгээрийг улс орны дотоод, гадаад зах зээлтэй холбосон эрчим хүч, зам харилцаа, орчин үеийн холбоо, мэдээлэл, бөөний худалдааны сүлжээг хамарсан нутаг дэвсгэрийн бүрдэл хэсгүүдтэй;** байхаар тусгасан.

Энэхүү бүсчилсэн хөгжлийн тухайд баримтлах бодлогын “**ирээдүй сайтай байршсан хот, сум, сууринг түлхүү хөгжүүлэх**”-гийн тухай ойлголт нь Эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах үндэс

болох юм. Иймд энэхүү Орон нутгийн бодлогын судалгааны хүрээнд **хөгжлийн ирээдүй сайтай сум, сууринг тодорхойлох** зорилтыг дэвшүүлсэн болно.

Нөгөө талаас, Орон нутгийн түвшинд хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, сум, суурин газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох нь Бүсчилсэн хөгжлийн бодлогод тухайн сум, сууринг газрыг хөгжүүлэх асуудал шууд тусгалаа олох, эдийн засгийн ялгавартай бодлого явуулах үндэс болно.

Үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот, сум сууринг тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлэх нь Бүсчилсэн хөгжлийн нэг чиглэл болно. Хөгжлийн ирээдүй сайтай **сум, сууринг** тодорхойлох орон зайн анализ, судалгааг дараахь шалгуур үзүүлэлтээр тодорхойллоо.

Ингээд хөгжлийн ирээдүй сайтан сум сууринг газрын тодорхойлох 5 ангилалын 14 салбар, чиглэлийн 21 шалгуур үзүүлэлтийг боловсрууллаа.

I. Хүн ам, нийгэм

- Хүн ам
- Нийгмийн үйлчилгээ

II. Эдийн засагы

- Эдийн засгийн чадавхи
- Уул уурхай, хүнд аж үйлдвэрлэлийн салбар
- Аж үйлдвэрлэлийн салбар
- Хөдөө аж ахуйн салбар
- Аялал жуулчлал

III. Дэд бүтэц

- Нийтийн аж ахуйн дэд бүтцийн хангамж
- Эрчим хүч
- Тээврийн дэд бүтэц

IV. Байгаль орчин

- Байгалийн бүс
- Усны нөөц
- Уур амьсгал

V. Газарзүйн байршил

- Газарзүйн оновчтой байршил

гэсэн ангилалын хүрээнд холбогдох салбар чиглэл, шалгуур үзүүлэлтийн нэр, шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал, хэмжигдэхүүн, хамрах хүрээ, түвшин болон тайлбар мэдээллийн эх сурвалж хамруулан дараахь хүснэгтэд харууллаа.

Эдгээр 21 шалгуур үзүүлэлтээс Хүн ам, Уул уурхай, хүнд аж үйлдвэрлэлийн салбар, Аж үйлдвэрлэлийн салбар, Хөдөө аж ахуйн салбар, Тээврийн дэд бүтэц болон Газарзүйн оновчтой байршилтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүдийг “Baseline indicator” буюу суурь үзүүлэлт болгон авлаа.

4.2. Орон нутгийн хөгжил байршлийн анализ

Өмнөх хэсэгт дурьдсанчлан Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд эдийн засгийн **нийтлэг** болон **ялгавартай** бодлогыг авч хэрэгжүүлэх нь чухал бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд аль бүс нутаг ямар хот, сум, суурин газар эдийн засгийн аль салбарт хөгжлийн илүү ирээдүй сайтай буюу потенциалтай байгааг тодорхойлох нь чухал билээ.

Энэ агуулгаар Хөгжлийн ирээдүй сайтай сум сууринг тодорхойлох 21 шалгуур үзүүлэлт үзүүлэлтээр Монгол Улсын 330 сум, орон нутгийн түвшинд хөгжил, байршлийн орон зайн анализ хийлээ. Ингээд өмнөх хүснэгтэд дурьдсан аргачлалын дагуу орон зайн анализ хийсэн зураглалуудыг харуулж байна.

4.2.1. Хүн ам, нийгмийн хөгжил, байршлийн зураглал

Хот, хөдөөгийн хүн амын суурьшил

Хэдийгээр Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулиар хотын эрхзүйн байдлыг тодорхой түвшинд тогтоож өгсөн боловч Засгийн газар, УИХ-аас томоохон хот, суурин газарт албан ёсоор Аймгийн болон Улсын зэрэглэл олголгүй өнөөг хүрсэн бөгөөд орон нутгийн түвшинд зөвхөн аймаг, сумын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтаар явж ирсэн нь өнөөгийн 21-р зуунд хотжилтын үйл явц эрчимтэй явагдаж, бүс, орон нутгийн түвшинд хөгжлийн томоохон үүрэг, роль бүхий хотуудыг байгуулж, улмаар хөрөнгө оруулалт, удирдлага, зохион байгуулалт, эдийн засгийн бие даасан байдлыг хангаж өгөх замаар хөгжилд хүрэх хэрэгцээ шаардлагад сөрөг нөлөө үзүүлж байна.


Дараахь зураг-3-д хүн амын нутагшилт, суурьшлийг хот ба хөдөөгөөр ангилан, хотыг дотор нь Тосгон, Аймгийн зэрэглэлтэй хот, Улсын зэрэглэлтэй хот; хөдөөг дотор нь 3000-аас доош хүн амтай сум суурин, 3000-8000 хүн амтай сум, суурин, 8000-аас дээш хүн амтай сум, суурин гэж ангилан 1996, 2006, 2017 онуудаар харууллаа.

Хүн амын нутагшилт, суурьшлийн гео-орон зайн анализ хийхдээ 2017 оны зураг дээр Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан төмөр зам, авто замтай холбоотой төсөл (коридор)-үүдийг нэмж, уг коридорын маршрутын дагуух бүс нутаг, хот, аймгийн төв, сум, суурин газрын хүн ам хэрхэн өөрчлөгдөж, суурьшиж байгаад орон зайн шинжилгээ хийж, харуулсан болно (Зураг 37).


Мөн хот, хөдөөгийн хүн амын суурьшлийн зураглал Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдан хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төмөр зам, авто замтай холбоотой, бүтээн байгуулалтын шинжтэй 9 төсөл (коридор)-ийн эхлэл болон төгсгөлийн цэгийн хотын нэр, маршрутын агуулга нэр, түүний дайран өнгөрч буй тухайн улсын бүс, хот, тосгон, хилийн болон далайн боомтыг тухайн хөтөлбөрт тусгагдсан нэршилээр нь Газарзүйн мэдээллийн систем (GIS)-д зураглал хийн оруулсан болно.

Энэ нь ирээдүйд аль хот, сум, суурин газар илүү хөгжлийн потенциал хүлээгдэж байгааг болон одоогийн нөхцөл байдлыг харуулна.


Зураг 35. Хот, тосгон болон сум суурин газар, хүн амын тооны ангиллаар, 1996 он



Зураг 36. Хот, тосгон болон сум суурин газар, хүн амын тооны ангиллаар, 2006 он



Зураг 37. Хот, тосгон болон сум суурин газар, хүн амын тооны ангиллаар, 2017 он болон Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор



*Хүснэгт 11. Монгол Улсын эдийн засгийн бүсүүдэд хамрагдах хот, тосгон болон сум, суурин газар,
хүн амын тооны ангилал болон 1996, 2006, 2017 оноор*

№	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлийн өнөөгийн байдал: Хот, тосгон болон сум, суурин газрын ангилалаар	Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001)ийн хүрээнд тогтоосон эдийн засгийн бүсүүдээр											
		Баруун бүс			Хангайн бүс			Төвийн бүс			Зүүн бүс		
		1996	2006	2017	1996	2006	2017	1996	2006	2017	1996	2006	2017
	Хот, тосгон, нийт	5	5	5	6	6	6	7	7	7	3	3	3
	• <15000 буюу Тосгон	0	0	0	1	1	1	3	4	3	0	1	1
	• 15000÷50000 буюу Аймгийн зэрэглэлтэй хот	5	5	5	4	4	4	3	2	3	3	2	2
	• 50000< буюу Улсын зэрэглэлтэй хот	0	0	0	1	1	1	1	1	1	0	0	0
	Сум, суурин, нийт	86	86	86	93	93	93	88	88	88	42	42	42
	• <3000 хүн амтай	33	48	54	26	27	25	62	63	60	25	27	25
	• 3000÷8000 хүн амтай	50	32	28	66	64	66	23	22	24	16	14	16
	• 8000< хүн амтай	3	6	4	1	2	2	3	3	4	1	1	1

Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийн хувьд **Төвийн бүсээр** дайран өнгөрч буй Төмөр замын төв коридор болон Азийн авто замын сүлжээ АН-3 чиглэлийн дагуу нийт 6 хот, тосгон байгаа бөгөөд үүнээс 15000-аас доош хүн амтай 1 тосгон, 15000÷50000 хооронд хүн амтай Аймгийн зэрэглэлийн 3 хот, харин 50000-аас дээшх хүн амтай Улсын зэрэглэлийн Дархан, Улаанбаатар гэсэн 2 хот байна.

Эдийн засгийн **Баруун бүсээр** төлөвлөсөн Төмөр замын баруун коридорын дагуу 1 хот буюу баруун бүсийн тулгуур төв Ховд хотоор, мөн нийт 18 сум, суурингаар дайран өнгөрөхөөр харагдаж байна. Харин Азийн авто замын АН-4 буюу баруун чиглэлийн авто замын хувьд Өлгий, Ховд гэсэн 2 хотоор, мөн нийт 23 сум суурингаар дайран өнгөрөхөөр харагдаж байна.

Эдийн засгийн **Зүүн бүсээр** төлөвлөсөн Төмөр замын зүүн коридорын дагуу 1 хот буюу зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотоор, мөн нийт 10 сум, суурингаар дайран өнгөрөхөөр харагдаж байна. Мөн Түмэн голын тээврийн коридор Далайн эрэг-2, Төмөр замын тээврийн Далайн эрэг-1 коридорууд Чойбалсан хотоор, нийт 6 сум суурингаар дайрахаар байна. Харин Авто замын зүүн коридорын хувьд Чойбалсан, Баруун-Урт гэсэн 2 хотоор, мөн нийт 12 сум суурингаар дайран өнгөрөхөөр харагдаж байна.

Гурван улсын төмөр зам, авто замын коридорууд нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөхдөө хүн амын хувьд харилцан адилгүй ямар хот, тосгод болон сум, суурингаар дайран өнгөрөхөөр байгаа тухай бусад мэдээллийг Зураг 37, Хүснэгт 12-оос харж болно.

Хот, хөдөөгийн хүн амын өөрчлөлт



Улсын нийслэл, бүсийн болон аймгийн төв 22 хот болон 309 сумдын түвшинд хүн амын өөрчлөлтийг “Хүн амын жилийн дундаж өсөлт, бууралт” тооцох аргачлалаар³⁹ 1990-2000, 2000-2010, 2010-2017 гэсэн гурван арван жилээр тооцоолж зураг-4-д харууллаа.

Аймгийн төв болон сумдын хүн амын өөрчлөлтийг тухайн аймгийн төв болон сум бүр дээр тооцоолж, улмаар нийт хугацаанд буюу 1990-2017 оны хооронд Улсын хэмжээнд хүн амын жилийн дундаж өсөлт 1.95% байжээ. Аргазүйн хэсэгт дурьдсанчлан тухайн аймгийн төв болон сумдын хүн ам “буурсан”, “хэвийн өссөн”, “механик өсөлттэй” гэсэн 3 ангиллаар хүн амын өөрчлөлтийг тооцож, орон зайн зураглалыг хийсэн болно.


2010-2017 оны хооронд тооцоолсон хүн амын өөрчлөлттийн гео-орон зайн анализ зураг дээр Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан төмөр зам, авто замтай холбоотой төсөл (коридор)-үүдийг нэмж, уг коридорын маршрутын дагуух бүс нутаг, хот, аймгийн төв, сум, суурин газрын хүн амын жилийн дундаж өсөлт, бууралтыг орон зайн шинжилгээ хийж, харуулсан болно (Зураг 40).

³⁹ Үндэсний статистикийн хороо. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал. Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/152 тоот тушаалын хавсралт. Улаанбаатар.

Энэ нь ирээдүйд аль хот, сум, суурин газар илүү хөгжлийн потенциал хүлээгдэж байгааг болон одоогийн нөхцөл байдлыг харуулна.



Зураг 40. Хүн амын өөрчлөлт: 2010-2017 оны хооронд хүн амын жилийн дундаж өсөлт, бууралт болон Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор



Хүснэгт 12. Хүн амын өөрчлөлт, хүн ам нь өссөн болон буурсан аймгийн төв, сумдын тоо

№	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлийн өнөөгийн байдал: Бүсийн болон аймгийн төв, сумдын хүн амын өөрчлөлт	Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001)ийн хүрээнд тогтоосон эдийн засгийн бүсүүдээр											
		Баруун бүс			Хангайн бүс			Төвийн бүс			Зүүн бүс		
		1990-2000	2001-2010	2011-2017	1990-2000	2001-2010	2011-2017	1990-2000	2001-2010	2011-2017	1990-2000	2001-2010	2011-2017
Хүн амын өөрчлөлт, Бүсийн болон аймгийн төв													
	• Буурсан	4	1	0	3	0	0	6	1	0	3	0	0
	• Хэвийн өссөн	1	4	3	1	2	4	1	3	3	0	3	1
	• Механик өсөлттэй	0	0	2	2	4	2	0	3	4	0	0	2
Хүн амын өөрчлөлт, сумдаар													
	• Буурсан	23	83	31	11	73	25	26	63	29	8	33	7
	• Хэвийн өссөн	42	3	45	37	19	57	42	16	59	21	9	32
	• Механик өсөлттэй	21	0	10	45	1	11	20	9	0	13	0	3

Хүснэгт 14. Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын дагуух аймгийн төв болон сумын төвийн хүн амын өөрчлөлт, 2017 оны байдлаар

№	Гурван улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн төмөр зам, автозамтай холбоотой коридор	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	Хүн ам нь өссөн, буурсан аймгийн төвийн тоо, эдийн засгийн коридорын дагуух			Хүн ам нь өссөн, буурсан сумдын тоо, эдийн засгийн коридорын дагуух			
			Эдийн засгийн бүс	Буурсан	Хэвийн өссөн	Механик өсөлттэй	Буурсан	Хэвийн өссөн	Механик өсөлттэй
1	Төмөр замын төв коридор	Иж бүрэн шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах эдийн засгийн үндэслэлийг судлах	Төвийн бүс	0	3	3	4	28	2
2	Төмөр замын хойд коридор	Судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх	Төв, Хангай бүс	0	0	2	13	38	6
3	Төмөр замын	Судалж, эдийн засгийн	Баруун бүс	0	1	0	8	9	1

	баруун коридор	үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх							
4	Төмөр замын Зүүн коридор	Судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх	Зүүн бүс	0	1	0	2	7	1
5	Түмэн голын тээврийн коридор (Далайн эрэг-2)	Өргөжүүлэх төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлнэ	Зүүн бүс	0	1	0	1	4	1
6	Төмөр замын тээврийн Далайн эрэг-1 коридор	Өргөжүүлэх төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх	Зүүн бүс	0	1	0	1	4	1
7	Азийн авто замын сүлжээ АН-3	Чиглэлийг дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхитэй ашиглах, тус чиглэлд хурдны автозам барих эдийн засгийн үндэслэлийг судлах	Төвийн бүс	0	3	3	7	29	5
8	Азийн авто замын АН-4	Чиглэлийг бүтээн байгуулж, дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхитэй ашиглах	Баруун бүс	0	1	1	5	14	4
9	Авто замын зүүн коридор	Төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх	Зүүн бүс	0	1	1	1	10	1


Эдийн засгийн **Баруун бүсээр** төлөвлөсөн Төмөр замын баруун коридорын дагуух Ховд хотын хүн ам хэвийн өссөн, мөн нийт 18 сум суурингаас 8 сум суурингийн хүн ам буурсан, 9 нь өссөн, 1 сум суурин механик өсөлттэй байна. Харин Азийн авто замын АН-4 буюу баруун чиглэлийн авто замын хувьд Өлгий хот механик өсөлттэй, Ховд хот хэвийн өсөлттэй бол дайран өнгөрөх нийт 23 сум суурингаас 5 сум суурингийн хүн ам буурсан, 14 нь хэвийн өссөн, 4 нь механик өсөлттэй байна.

Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийн хувьд **Төвийн бүсээр** дайран өнгөрч буй Төмөр замын төв коридор болон Азийн авто замын сүлжээ АН-3 чиглэлийн дагуу нийт 6 хот, тосгон байгаа бөгөөд үүнээс 3 хот тосгоны хүн ам хэвийн өссөн, 3 хот тосгоны хүн ам механик өсөлттэй байна. Харин төмөр замын коридорын дагуух 34 сум суурингаас 4 сум суурингийн хүн ам

буурсан, 28 сум суурингийн хүн ам хэвийн өссөн, 2 сум суурингийн хүн ам механик өсөлттэй байна. АН-3 Азийн автозамын сүлжээний дагуу 41 сум суурингаас 5 сум суурингийн хүн ам буурсан, 29 сум суурингийн хүн ам хэвийн өссөн, 5 сум суурингийн хүн ам механик өсөлттэй байна.

Эдийн засгийн **Зүүн бүсээр** төлөвлөсөн Төмөр замын зүүн коридорын дагуу 1 хот буюу зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотын хүн ам хэвийн өсөлттэй, 10 сум суурингийн 2 сум суурингийн хүн ам буурсан, 7 сум суурингийн хүн ам хэвийн өссөн, 1 сум суурингийн хүн ам механик өсөлттэй байна. Харин Авто замын зүүн коридорын хувьд Чойбалсан хот хэвийн өссөн, Баруун-Урт хот механик өсөлттэй бол дайран өнгөрөх 12 сум суурингаас 1 сум суурингийн хүн ам буурсан, 10 сум суурингийн хүн ам хэвийн өссөн, 1 сум суурингийн хүн ам механик өсөлттэй байна.

Зураг 41. Боловсролын үйлчилгээний зураглал, сумдын түвшинд




Дараахь индексжүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн авсан. Аймгийн төв, хотуудыг хамруулаагүй болно.

- Сумын 1-5 ангид сурах ёстой хүүхдийн хамрагдалтын хувь
- 1 багшид ногдох сурагчдын тоо
- Сургуулийн ээлжийн коэффициент
- 1 хүүхдэд ногдох дотуур байрны орны тоо
- Цэцэрлэгийн хүчин чадал ба хүүхдийн харьцаа

➤ Цэцэрлэгийн 1 үндсэн багшид ногдох хүүхдийн тоо

Зураг 42. Эрүүл мэндийн үйлчилгээний зураглал, сумдын түвшинд




Эх сурвалж: www.ldi.ndi.gov.mn

Дараахь индексжүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн нэгтгэн авсан. Аймгийн төв, хотуудыг хамруулаагүй болно.

- Нэг их эмчид ногдох хүний тоо
- Нэг сувилагчид ногдох хүний тоо
- 10000 хүнд ногдох зүрх судасны тогтолцооны өвчнөөр нас барсан хүний тоо

- 10000 хүнд ногдох хавдараар нас барсан хүний тоо
- 0-4 насны хүн амын нас баралтын дундаж түвшин

4.2.2. Эдийн засаг, үйлдвэрлэлийн салбарын хөгжил байршлийн зураглал




Дараахь индексжүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн авсан. Аймгийн төв, хотуудыг хамруулаагүй болно.

- 1000 хүнд ногдох зочид буудлын орны тоо (зөвхөн ХХК)
- Ахуйн үйлчилгээний төрлийн тоо
- 1000 хүнд ногдох НДШ төлж байгаа хувийн хэвшлийн ажилчдын тоо
- 1000 хүнд ногдох 15-64 насны цэвэр шилжин ирэгсэдийн тоо
- 1 хүнд ногдох сумын нийт татвар төлөгчдөөс сум, аймаг, улсын төсөвт төвлөрүүлсэн татварын хэмжээ /сая төг/


- 1 хүнд ногдох хадгаламжийн үлдэгдэл (сая төг)
- 1 хүнд ногдох зээлийн үлдэгдэл (сая төг)

Зураг 44. Уул уурхай, ашигт малтмалын байршил, дэд бүтцийн хөгжлийн зураглал




Ашигт малтмалын стратегийн ач холбогдолтой орд газар, байршил + Уул уурхайн томоохон олборлолт, хайгуул явагдаж байгаа уурхайн байршил + Авто зам, төмөр замын сүлжээний зураглал (одоо байгаа болон төлөвлөгдсөн)


Зураг 45. Уул уурхай, ашигт малтмал болон Хүнд үйлдвэрлэлийн төслийн байршлийн зураглал




Зураг 46. Малын тооны өсөлтийн тархалтын зураглал, сумдын түвшинд




Зураг 47. Малын тоо, толгойн нөөцийн тархалтын зураглал, сумдын түвшинд



Зураг 48. Арьс, ширний нөөцийн тархалт ба Хот, сумд болон дэд бүтцийн байршил, сумдын түвшинд



Зураг 49. Боломжит ноосны нөөцийн тархалт ба Хот, сумд болон дэд бүтцийн байршил, сумдын түвшинд



Таних тэмдэг

- Аймгийн төв
- Улсын хил
- Аймгийн хил

Боомт

- Олон улсын байнгын ажиллагаатай
- Байнгын ажиллагаатай
- Түр ажиллагаатай

Тээврийн сүлжээ


- Төмөр зам
- Төлөвлөгдсөн төмөр зам
- Хатуу хучилттай авто зам
- Төлөвлөгдсөн авто зам

Боломжит ноосны нөөц мян.тон

- 0 - 52
- 52.1 - 104
- 104.1 - 224


- 5000 дээш хүн амтай сум
- Ноос боловсруулах үйлдвэр

Зураг 50. Боломжит ноолуурын нөөцийн тархалт ба Хот, сумд болон дэд бүтцийн байршил, сумдын түвшинд




4.2.3. Дэд бүтцийн салбарын хөгжил байршлийн зураглал


Зураг 51. Авто замын нэгдсэн сүлжээ (Одоо байгаа & төлөвлөгдсөн)




Зураг 52. Төмөр замын нэгдсэн сүлжээ (Одоо байгаа & төлөвлөгдсөн)




Зураг 53. Одоо байгаа болон төлөвлөгдсөн авто замын сүлжээ ба Хот, сумдын байршил




Зураг 54. Одоо байгаа болон төлөвлөгдсөн төмөр замын сүлжээ ба Хот, сумдын байршил




Зураг 55. Сумын төвийн цэвэр ус хангамж, ариутгах шугам сүлжээ, сумдын түвшинд



Зураг 56. Сумдын төвийн дулаан хангамжид холбогдсон байдал, сумдын түвшинд




Зураг 57. Эрчим хүчний хангамж, сүлжээ ба Хот, сумдын байршил, сумдын түвшинд




- Дараахь индексжүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн авна.
 - Төрийн байгууллагын цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон хувь
 - Сумын төвийн өрхийн цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон хувь
- Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээний нэгдсэн зураглал

4.2.4. Байгаль орчинтой холбоотой хөгжил байршлийн зураглал


Зураг 58. Байгалийн бүс бүслүүр ба сумдын байршил




Зураг 59. Экологийн бүсүүд дэх сумдын тоо




Зураг 60. Уур амьсгалын өөрчлөлтийн орон зайн тархалт нөлөө ба Хот, сумдын байршил






Зураг 61. Томоохон гол, нуурын сүлжээ болон Хот, сумдын байршил



Хүснэгт 15. Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, суурин, сумын төв, тосгон

	Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, суурин	Сумын төв, тосгон
	Хотын нэр, тоо	Хүн ам
		Тоо
Томоохон гол, нуурын эрэг дагасан суурьшил	Нийт 15 хот (Өлгий, Ховд, Улаангом, Улиастай, Мөрөн, Цэцэрлэг, Баянхонгор, Арвайхээр, Булган, Эрдэнэт, Дархан, Сүхбаатар, Улаанбаатар, Чингис, Чойбалсан)	Нийт 156 сумын төв (Баян-Өлгий 10, Увс 10, Завхан 12, Хөвсгөл 19, Булган 8, Архангай 14, Орхон 1, Дархан 3, Сэлэнгэ 15, Хэнтий 8, Төв 6, Дорнод 7, Сүхбаатар 1, Дундговь 1, Өмнөговь 1, Өвөрхангай 10, Баянхонгор 10, Говь-Алтай 2, Ховд 11)
Бусад	Нийт 7 хот (Алтай, Зуунмод, Даланзадгад, Мандалговь, Чойр, Сайншанд, Баруун- урт)	Нийт 160 сум, суурин (Баян-Өлгий 1, Увс 6, Завхан 11, Хөвсгөл 4, Булган 7, Сэлэнгэ 3, Хэнтий 13, Төв 17, Дорнод 6, Сүхбаатар 12, Говьсүмбэр 3, Дорноговь 14, Дундговь 13, Өмнөговь 13, Өвөрхангай 9, Баянхонгор 8, Говь-Алтай 10, Ховд 5)

Зураг 62. Гадаргын усны нөөц ба Хот, сумдын хүн амын тоо, байршил



Аймгийн төв, нийслэл

- ★ 15000 - доош хүн амтай 3 хот
- ★ 15001 - 50000 хүн амтай 16 хот
- ★ 50001 - дээш хүн амтай 3 хот

Сум, суурин

- 3000 - доош хүн амтай 174 сум, суурин
- 3001 - 10000 хүн амтай 131 сум, суурин
- 10001 - дээш хүн амтай 6 сум, суурин

Гадаргын усны ашиглах боломжит нөөц, сая м.куб

- Маш бага нөөцтэй 5 сав газар
- 0.01 - 80.00 нөөцтэй 16 сав газар
- 80.01 - 160.00 нөөцтэй 3 сав газар
- 160.01 - 240.00 нөөцтэй 2 сав газар
- 240.01 - 401.10 нөөцтэй 3 сав газар


Усны сав газрын нэр

1 Сэлэнгэ	16 Мэнэнгийн тал
2 Хөвсгөл	17 Умард говийн гүвээт-Халхындундад
3 Шишхэд	18 Галба-Өөш - Долоодын говь
4 Дэлгэрмөрөн	19 Онги
5 Идэр	20 Алтайн өвөр говь
6 Чулуут	21 Тээц
7 Хануй	22 Орог нуур - Түй
8 Орхон	23 Бөөншагаан нуур - Байдраг
9 Туул	24 Хяргас нуур - Залхан
10 Хараа	25 Хүйсийн говь - Цэцэг нуур
11 Ерөө	26 Үенч - Бодонч
12 Онон	27 Булган
13 Улз	28 Хар нуур - Ховд
14 Хэрлэн	29 Увс нуур - Гэс
15 Бүйр нуур - Халх	

4.2.5. Газарзүйн оновчтой байршлийн зураглал

Зураг 63. Бүлэг суурингийн тогтолцоо

Эх сурвалж: БХБЯамны Барилга, хот
байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний
төв. 2006 он



Бүлэг суурингийн тогтолцоо:


- Нийслэл, бүсийн тулгуур төв хот, аймгийн төв хотын **23**,
- Сум дундын **73**
- Нийт **96** бүлэг суурингийн тогтолцоо

Гол шалгуур:

- Аймаг, орон нутгийн санал
- Төрийн захиргааны төв байгууллагын санал
- Тухайн аймаг, сумдын нутаг дэвсгэрийн хэмжээ, хот, төв суурингийн тоо, нягтрал, өөр хоорондын зай, замын бартаажилт зэргийг үндэслэн

4.2. Нэгдсэн орон зайн анализын дүн: Хөгжлийн ирээдүй сайтай сум, суурин газар

Монгол Улсын 330 сумын түвшинд хүн ам, нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэл, дэд бүтцийн тээвэр болон газарзүйн байршлийн хувьд орон зайн анализ хийж, үр дүнд тулгуурлан нэгдсэн байдлаар Хөгжлийн ирээдүй сайтай сумдын байршлийг харууллаа.



Хүснэгт 13. Хөгжлийн ирээдүй сайтай сум, суурингийн газар

№	Аймгийн нэр	№	Сумын нэр	Суурь индекс/хүн ам, дэд бүтэц/	Эдийн засгийн индекс /УУ, МАА, АЖ/	Нийт индекс	Бүлэг суурингийн төв	Тайлбар
8	Завхан	1	Их-Уул	2	0.7	2.7	Тосонцэнгэл	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, МАА, АЖ нөөцтэй
13	Завхан	2	Тосонцэнгэл	2	0.7	2.7	Тосонцэнгэл	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, МАА, АЖ нөөцтэй
37	Говь-Алтай	3	Цээл	0	1	1	Есөнбулаг	Уул уурхайн нөөцтэй
38	Говь-Алтай	4	Чандмань	0	1	1	Бигэр	Уул уурхайн нөөцтэй
44	Баян-Өлгий	5	Бугат	2	0	2	Өлгий	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон
48	Баян-Өлгий	6	Ногооннуур	2	1.2	3.2	Цагааннуур	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, УУ, АЖ нөөцтэй
49	Баян-Өлгий	7	Сагсай	2	0.7	2.7	Өлгий	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, МАА, АЖ нөөцтэй
50	Баян-Өлгий	8	Толбо	1.5	1.7	3.2	Өлгий	Улсын чанартай авто замд холбогдсон, УУ, МАА, АЖ нөөцтэй
51	Баян-Өлгий	9	Улаанхус	2.5	0.7	3.2	Өлгий	Хүн амын тоо их, механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон, МАА, АЖ нөөцтэй
52	Баян-Өлгий	10	Цэнгэл	1.5	0.7	2.2	Өлгий	Хүн амын тоо их, механик өсөлттэй, МАА, АЖ нөөцтэй
54	Ховд	11	Булган	2	0.2	2.2	Булган	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, АЖ нөөцтэй

56	Ховд	12	Дарви	2	1.5	3.5	Зэрэг	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон, УУ, МАА нөөцтэй
66	Ховд	13	Цэцэг	2	0.2	2.2	Зэрэг	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон, УУ, МАА нөөцтэй
70	Увс	14	Бөхмөрөн	1	1	2	Улаангом	Улсын чанартай авто замд холбогдсон, УУ нөөцтэй
71	Увс	15	Давст	1	1.2	2.2	Сагил	Улсын чанартай авто замд холбогдсон, УУ, аялал жуулчлалын нөөцтэй
78	Увс	16	Өмнөговь	1.5	1	2.5	Өмнөговь	Улсын чанартай авто замд холбогдсон, УУ нөөцтэй
81	Увс	17	Тариалан	1	1	2	Улаангом	Улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ нөөцтэй
87	Орхон	18	Жаргалант	2	0	2	Баян-Өндөр	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон
97	Өвөрхангай	19	Нарийнтээл	1.5	1	2.5	Баянтээг	Улсын чанартай авто замд холбогдсон, УУ нөөцтэй
104	Өвөрхангай	20	Хархорин	2	0.7	2.7	Хархорин	Хүн амын тоо их, улсын чанартай автозамд холбогдсон, МАА, АЖ нөөцтэй
111	Булган	21	Дашинчилэн	2	0.5	2.5	Дашинчилэн	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон, МАА нөөцтэй
115	Булган	22	Сайхан	0.5	1.5	2	Булган	УУ, МАА нөөцтэй
117	Булган	23	Тэшиг	1	1	2	Хутаг-Өндөр	Улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ нөөцтэй
129	Баянхонгор	24	Бөмбөгөр	2	0	2	Баянхонгор	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон
146	Архангай	25	Өндөр-Улаан	2	0.5	2.5	Тариат	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, МАА

							нөөцтэй	
147	Архангай	26	Тариат	1.5	1.7	3.2	Тариат	Улсын чанартай авто замд холбогдсон, УУ, МАА, АЖ нөөцтэй
148	Архангай	27	Төвшрүүлэх	1.5	1	2.5	Цэцэрлэг	Улсын чанартай авто замд холбогдсон, УУ өөцтэй
154	Архангай	28	Цэнхэр	2	0.5	2.5	Цэцэрлэг	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, МАА нөөцтэй
158	Хөвсгөл	29	Алаг-Эрдэнэ	2	1.2	3.2	Мөрөн	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, УУ, АЖ нөөцтэй
167	Хөвсгөл	30	Тариалан	2	0	2	Тариалан	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон
170	Хөвсгөл	31	Түнэл	2	0	2	Мөрөн	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон
176	Хөвсгөл	32	Цэцэрлэг	1	1.5	2.5	Цагаан-Уул	Улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ, МАА нөөцтэй
184	Төв	33	Баян	1	1	2	Багахангай	Улсын чанартай авто замд холбогдсон, УУ нөөцтэй
186	Төв	34	Баянжаргалан	0	1.5	1.5	Багахангай	УУ, МАА нөөцтэй
191	Төв	35	Баянчандмань	1.5	1	2.5	Баянчандмань	Улсын чанартай авто замд холбогдсон, УУ нөөцтэй
192	Төв	36	Борнуур	2	0	2	Баянчандмань	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон
195	Төв	37	Жаргалант	1	1.5	2.5	Баянчандмань	Хүн амын тоо их, УУ, МАА нөөцтэй
204	Төв	38	Эрдэнэ	0.5	1.7	2.2	Багануур	УУ, МАА, АЖ нөөцтэй
207	Говьсүмбэр	39	Шивээговь	2	1	3	Сүмбэр	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон, УУ нөөцтэй
208	Сэлэнгэ	40	Алтанбулаг	2	0.2	2.2	Сүхбаатар	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, АЖ нөөцтэй
210	Сэлэнгэ	41	Баянгол	2	0	2	Зүүнхараа	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон

211	Сэлэнгэ	42	Ерөө	1	1.2	2.2	Ерөө	Хүн амын тоо их, УУ, АЖ нөөцтэй
214	Сэлэнгэ	43	Мандал	2	1	3	Зүүнхараа	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон, УУ нөөцтэй
217	Сэлэнгэ	44	Сайхан	2	0	2	Хөтөл	Хүн амын тоо их, улсын чанартай авто замд холбогдсон
219	Сэлэнгэ	45	Түшиг	1	1	2	Цагааннуур	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ нөөцтэй
220	Сэлэнгэ	46	Хүдэр	1	1	2	Ерөө	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ нөөцтэй
222	Сэлэнгэ	47	Цагааннуур	2.5	0.5	3	Цагааннуур	Хүн амын тоо их, механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон, МАА нөөцтэй
226	Дорноговь	48	Даланжаргалан	1	1	2	Айраг	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ нөөцтэй
228	Дорноговь	49	Замын-Үүд	2.5	0	2.5	Замын-Үүд	Хүн амын тоо их, механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон
230	Дорноговь	50	Мандах	0	1	1	Сайншанд	УУ нөөцтэй
234	Дорноговь	51	Хатанбулаг	0	1.2	1.2	Зүүнбаян	УУ, АЖ нөөцтэй
235	Дорноговь	52	Хөвсгөл	0	1	1	Зүүнбаян	УУ нөөцтэй
238	Дархан-Уул	53	Хонгор	2	1.5	3.5	Дархан	Хүн амын тоо их, механик өсөлттэй, улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ, МАА нөөцтэй
239	Дархан-Уул	54	Шарын гол	1	1	2	Дархан	Хүн амын тоо их, УУ нөөцтэй
249	Өмнөговь	55	Ханбогд	2.5	0.2	2.7	Ханбогд	Хүн амын тоо их, механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон, АЖ нөөцтэй
253	Өмнөговь	56	Цогтцэций	2.5	0	2.5	Цогтцэций	Хүн амын тоо их, механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон

255	Дундговь	57	Баянжаргалан	0	1	1	Говь-Угтаал	УУ нөөцтэй
258	Дундговь	58	Дэлгэрхангай	0	1	1	Эрдэнэдалай	УУ нөөцтэй
263	Дундговь	59	Өндөршил	0	1	1	Гурвансайхан	УУ нөөцтэй
266	Дундговь	60	Цагаандэлгэр	0	1	1	Говь-Угтаал	УУ нөөцтэй
268	Дорнод	61	Баяндун	0.5	1	1.5	Баян-Уул	УУ нөөцтэй
269	Дорнод	62	Баянтүмэн	1.5	1	2.5	Хэрлэн	Хүн амын механик өсөлттэй, улсын чанартай авто замд холбогдсон, УУ нөөцтэй
273	Дорнод	63	Дашбалбар	0.5	1.5	2	Чулуунхороот	УУ, МАА нөөцтэй
274	Дорнод	64	Матад	1	1	2	Хэрлэн	Улсын чанартай авто замтай холбогдсон, УУ нөөцтэй
279	Дорнод	65	Чойбалсан	0.5	1	1.5	Хэрлэн	Улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ нөөцтэй
287	Сүхбаатар	66	Сүхбаатар	1.5	1.5	3	Баруун-Урт	Улсын чанартай авто замтай холбогдсон, УУ, МАА нөөцтэй
292	Сүхбаатар	67	Эрдэнэцагаан	1.5	1	2.5	Эрдэнэцагаан	Хүн амын тоо их, улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ нөөцтэй
302	Хэнтий	68	Дархан	0.5	1.5	2	Бор-Өндөр	Улсын чанартай авто зам тавихаар төлөвлөсөн, УУ, МАА нөөцтэй
305	Хэнтий	69	Мөрөн	1	1.5	2.5	Хэрлэн	Улсын чанартай авто замтай холбогдсон, УУ, МАА нөөцтэй
307	Хэнтий	70	Өмнөдэлгэр	1	1.5	2.5	Жаргалтхаан	Хүн амын тоо их, УУ, МАА нөөцтэй

Дүгнэлт, зөвлөмж

1. Монголын нөхцөлд бүсчилсэн хөгжлийн асуудалтай уялдуулан чанарын “Шалгуур үзүүлэлт”-ийг тодорхойллоо. Энэхүү шалгуур үзүүлэлтээр бүсчилсэн хөгжлийн асуудалтай уялдуулан аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээ хийлээ. Бодлогын шинжилгээнээс дараахь дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд,
 - Аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол агуулга, бодлогын зорилуудад чиглэсэн бүс нутгийн түвшинд хамтран хөгжих, нэгдэх агуулгатай хөгжлийн зорилтууд дутагдаж байна.
 - Бүсчилсэн хөгжлийн асуудлын хүрээнд өнөөгийн хууль эрхзүйн орчноор орон нутгийн түвшинд мөнхийн эрх ашиг гэж байхаас эрх үүрэг алга байна. Өөрөөр хэлбэл, ойролцоо тойргийн аймгууд бүсчилсэн хөгжилтэй холбоотой асуудалд өөр өөрсдийн эрх ашгийн үүднээс хөгжлийн зорилтуудыг дэвшүүлж, харин бүсчилсэн хөгжлийн хүрээнд тухайн аймаг, орон нутаг өөр хоорондоо харилцан бие биеэ дэмжих, хөгжлийн зорилтуудаа уялдуулан замаар ямар үүрэг, рольтой оролцох тухай эрхзүйн механизм, мөн ийм түвшний хөгжлийн зорилтуудыг дэвшүүлэхгүй байна.
 - Иймд аймаг, орон нутаг тухайн бүс нутгийн хөгжүүлэхэд ямар үүрэг, хариуцлагатай, уялдаа холбоотой ажиллах эрхзүйн орчин, механизмийн бүрдүүлэх шаардлагатай байна.
 - УИХ, Засгийн газраас батлагдсан салбарын болон үндэсний түвшний бодлого, хөтөлбөрүүд нь бүс нутаг, орон нутгийн түвшинд газарзүй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны өөр өөр нөхцөл, орчин, өгөгдөлд нийцүүлэн орон зайн хувьд харилцан адилгүйгээр хэрхэн хэрэгжүүлэх тухай төлөвлөлт дутагдаж байна. Өөрөөр хэлбэл, тухайн үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрийг орон зайн хувьд төлөвлөлөн хэрэгжүүлэх асуудал юм. Иймд Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах шатанд Төрөөс баримтлах бодлого, Үндэсний хөтөлбөрүүдийг эдийн засгийн бүсүүд дээр харилцан адилгүйгээр, тухайн орон нутагт нь нийцүүлэн төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх шаардлага байна.
 - Хэдийгээр бүсийн нутгийн түвшинд төлөвлөлт хийгээгүй ч аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт бүсчилсэн хөгжил, эдийн засгийн агуулгатай бодлогын ижил төстэй зорилт, арга хэмжээ дэвшүүлж байна. Гэхдээ эдгээр бодлогын зорилтуудад хамрагдаж байгаа оролцогч талуудыг хамтрах, өөр хоорондоо хоршин хөгжих зорилт дутагдаж байна.
 - Бүсчилсэн хөгжлийн асуудалтай холбогдуулан эдийн засаг, эрхзүйн орчны нийтлэг болон ялгаатай бодлого дутагдаж байна. Үндэсний хэмжээнд, бүс нутгийн хөгжлийг түргэтгэх, тодорхой нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах шаардлагатай байна.
2. Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот сууринг тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлж, түүнд ойр байгаа бусад нутгийг татан оролцуулах нь бүсчилсэн хөгжлийн хүрээнд орон нутгийн түвшинд авч үзэх нэг чухал асуудал бөгөөд бүсчилсэн хөгжлийн хувьд дэмжих механиз хэлбэрээр

авч үзэх, хөрөнгө оруулалтын нэмэгдүүлэх шаардлагатай хөгжлийн ирээдүй сайтай дээрх 70 сумын тодорхойлж байна.

3. Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлсон Баруун болон Зүүн бүсийн тулгуур төв хот болон бусад аймгийн төв хотуудаар Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт туссан төмөр зам, авто замын коридорууд дайран өнгөрч байна. Энэ нь Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцэж байгаа бөгөөд бүсийн түвшинд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд Төр, засгаас бодлогын түвшинд гурван улсын төмөр зам, авто замын төслүүдийн бүтээн байгуулалтыг цааш явуулахад түлхүү анхаарах шаардлагатай. Учир нь өмнө үзүүлсэнчлэн төв рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс улбаатай сөрөг нөлөөлийн улмаас гадаад хүчин зүйлсийг нөхцөлдүүлж, улмаар хөрөнгө оруулалт зогсонги байдал орох эсрдэлтэй юм. Нөгөө талаас Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт төмөр замын баруун болон зүүн коридорыг “судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх” гэж тусгасан. Иймд Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын баруун болон зүүн коридорыг Бүсчилсэн хөгжлийн бодлого, орон нутгийн хөгжлийн асуудалтай уялдуулан түлхүү дэмжих шаардлагатай байна.
4. Хүн амын нутагшилт, суурьшил талаас авч үзвэл Улаанбаатар хотод нийт хүн амын 46 хувь нь, цаашид энэ хандлагаар үргэлжилбэл 2040 онд 65 хувь нь зөвхөн Нийслэлд төврөлөн суурьших “сөрөг” үр дагавар хүлээж байна. Мөн нийгэм, эдийн засаг, боловсрол, соёл, улс төрийн хэт төвлөрөл Улаанбаатар хотод бий болжээ. Бүсийн тулгуур 8 төв хотыг, одоогийн Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулиар 21 аймгийн төв Улсын зэрэглэлтэй хот байгаа бөгөөд 21 хотыг зэрэг хөгжүүлэх эдийн засгийн боломж хомс юм. Иймд эхний ээлжинд нийгэм, эдийн засаг, соёлын үйлчилгээгээр Улаанбаатар хоттой тэнцэхүйц буюу өрсөлдөхүйц 3-4 томоохон хотыг байршлын хувьд аль болох зангилаа цэг, нөгөө талаас гурван эдийн засгийн коридорын дагуу оновчтой сонгож, улмаар Улсын зэрэглэлтэй хот болгон түлхүү хөгжүүлэх шаардлагатай байна.
5. Эдийн засгийн хувьд хөгжлийн харьцангуй ирээдүй сайтай бүс нутаг, хот, сум суурин газрыг 1). Газарзүйн оновчтой байршилаа харгалзсан; 2). Бүсчилсэн хөгжлийн бодлого, дэд бүтцийн босоо болон хэвтээ тэнхлэгээ зангилаа, цаашдын хөгжлийн төлөвлөлтийг харгалзсан; 3). Бүс нутгийн эдийн засгийн интеграци, эдийн засгийн коридорын тэгш, хүртээмжтэй төлөвлөлтийг дэмжсэн; 4). Хот байгуулж хөгжих орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хүн амын хэт төвлөрлийг сааруулж, улмаар бүс нутгийн түвшинд томоохон хотыг бий болгож хүн амын тогтвортой, тэнцвэртэй суурьшлийг дэмжсэн; 5). Хөрөнгө оруулалт, татвар, санхүүгийн хөнгөлөлттэй, урамшуулалтай механизм, эрхзүйн орчинг бүрдүүлж, улмаар тээвэр, худалдаа, ложистикийн томоохон төвлөрөл бий болсон 6). Нийгэм, эдийн засаг, соёл, үйлчилгээний хувьд Улаанбаатар хоттой өрсөлдөхүйц Улсын зэрэглэлтэй хотуудыг бий болгох, тодорхойлох хэрэгцээ шаадлага байна. Ингэснээр Монгол Улс Бүсчилсэн хөгжлийн тухайд баримтлах бодлого, төлөвлөлтийн хувьд олон улсын бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ. Ингэхдээ эрхзүйн болон эдийн засагийн дараахь арга хэрэгслэлүүдийг ашиглах нь зүйтэй. Үүнд,

- *Санхүүгийн дэмжлэг үзүүлэх.* Тухайлбал, Төрөөс бодлогын түвшинд хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот, сум, суурин газарт хөрөнгө оруулалтыг түлхүү хийх, татварын хөнгөлөлт үзүүлэх, ажлын байр шинээр бий болгосны урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх, тээврийн хөнгөлөлт үзүүлэх г.м.
 - *Бизнесийн орчинг сайжруулах.* Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллага дээрх 3-4 томоохон хотод төв ажлын байраа байгуулж, ажлын байр нэмэгдүүлсэн тохиодолд хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх.
 - *Удирдлага, зохион байгуулалтын бүтцийг сайжруулах.* Удирдлага, зохион байгуулалтын хувьд хуулиар олгогдох эрхзүйн хэм хэмжээг нэмэгдүүлэх, Улаанбаатар хоттой ижил эрхзүйн хэм хэмжээтэй болгох.
 - *Дэд бүтцийн үйлчилгээг сайжруулах.* Интернет, эрчим хүч, зам тээвэр, агаарын тээвэр, олон улсын шууд нислэг зэрэг дэд бүтцийн үйлчилгээг түлхүү хөгжүүлэх.
6. Эцэст нь дүгнэхэд, Аймаг, орон нутгийн түвшинд Бүсчилсэн хөгжилтэй холбоотой 1). Үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрөл, хоршилт, төрөлжилт; 2). Бүс нутгийн зах зээлийн өрсөлдөөн, худалдаа, экспорт, импорт; 3). Коридор /эдийн засгийн, тээвэр хөгжлийн, ногоон хөгжлийн/; 4). Кластерийн тухай ойлголт болон бүс, орон нутгийн түвшинд нөөц, чадавхид тулгуурласан өрсөлдөх чадвар сайтай хэд хэдэн кластерийг авч үзэх; 5). Судалгааны институт, аж үйлдвэрийн дэд бүтэц, хэрэглэгч, үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн сүлжээ торлог хэлбэрээр авч үзэх; 6). Хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот сууринг тодорхойлох, тэргүүн ээлжинд хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг суурь ойлголт, асуудлуудыг бодлогын түвшинд авч үзэх шаардлагатай байна.

ТАВ. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ СХЕМ, ХАВСРАЛТУУД

7.1. Ашигласан материалын жагсаалт

1. M.Altanbagana et al. 2016. Consulting on “National Report of Urban Development of Mongolia for UN HABITAT III” and “Current Assessment for Regional and Human Settlements Development in Mongolia”. Funding by Ministry of Construction and Urban Development and UNDP and Introduced to the United Nations Conference on Housing and Sustainable Urban Development in Quito, Ecuador, from 17-20 October, 2016.
2. M.Altanbagana. 2018.03.10. “Sustainable Development Vision 2030 and Challenges in Mongolia: Zud Impact on Social-Economic Issues”. Symposium on “Changing Environment and People's live of Mongolia” in Tottori University. Japan
3. М.Алтанбагана, Б.Хэрлэнбаяр. 2015. “Экологийн эмзэг байдал шилжилт хөдөлгөөн, ядууралд нөлөөлөх нь”. Нийгэм эдийн засгийн хөгжилд байгалийн нөхцөл, нутаг дэсвгэрийн онцлогийг харгалзан үзэх нь сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний 3-р бага хурал. Улаанбаатар
4. B.Enkhbaigali, D.Tumurpurev, M.Altanbagana et al. 2016. Research report on “Sustainable Development Concept of Mongolia 2040”. Endorsed by decree No. 19 of 2016 issued by the Parliament of Mongolia. The National Development Institute of Mongolia. Ulaanbaatar.
5. B.Enkhbaigali, M.Altanbagana, D.Tumurpurev and et all. 2014. Brochure on “Implementation Assessment of National Development Comprehensive Strategy based on Millennium Development Goals”. National Development Institute. Ulaanbaatar.
6. M.Altanbagana, D.Battogtokh, B.Kherlenbayar. 2018. “Geo-Spatial Analysis for Human Resources and settlement based National Development Policies in Mongolia along with Economic Corridors”. Proceedings of International Geographic Conference on Economic Corridor “China-Mongolia-Russia”: Geographical and Environmental Concerns and Spatial Development Perspectives. pp 212. August 20-26, 2018, Irkutsk, Russia.
7. M.Altanbagana, B.Kherlenbayar. 2015. “Ecological Vulnerability and Its Impact on Migration and Poverty”. Proceedings of 3rd International Conference on Considering the Socio-Economic Development for the Peculiarities of Natural Condition and Territorial. Pp 224. Ulaanbaatar.
8. Л.Цэдэндамба. 2005. “Монгол Улсын Эдийн засгийн бүсүүдийн төв (хот, суурин газар)-ийн хөгжлийг төрөөс дэмжих онолын үндэслэл, арга зам” ШУТ-ийн төслийн тайлан. Улаанбаатар
9. Л.Цэдэндамба. 2004. “Монгол Улсад бүс нутгуудийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах онолын үндэс, аргазүй, аргачлал”. Үндэсний хөгжлийн хүрээлэн, Бүс нутгийн хөгжлийн судалгаа, сургалтын төв. Улаанбаатар.
10. Япон Улсын Тогтвортой хөгжлийн шалгуур.

http://pub.iges.or.jp/modules/envirolib/upload/3286/attach/pb_12_e_final.pdf

11. “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”. УИХ-ын 2016 оны 19 дугаар тогтоол.
12. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол. Улаанбаатар
13. Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. Улаанбаатар
14. Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр. 2016. Ташкент хот.
15. Гурван тулгуурт хөгжлийн бодлого. Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоол. Улаанбаатар
16. Үйлдвэржилт 21:100” Үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоол. Улаанбаатар
17. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого. УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоол. Улаанбаатар
18. Ерөнхий сайдын 2017 оны 165 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг. Улаанбаатар
19. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол. Улаанбаатар.
20. Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хууль. УИХ-ийн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэр. Улаанбаатар.
21. Үндэсний статистикийн хороо. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал. Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/152 тоот тушаалын хавсралт. Улаанбаатар.
22. Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоол. Ноолуур хөтөлбөр (2018-2021). Улаанбаатар.
23. УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.
24. Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоол. Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого. Улаанбаатар.
25. Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.
26. УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол. Ногоон хөгжлийн бодлого. Улаанбаатар
27. Засгийн газрын 2015 оны 474 дүгээр тогтоол. МУ-ын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр. Улаанбаатар.
28. УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Улаанбаатар.
29. Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоол. “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр. Улаанбаатар.
30. Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр. Улаанбаатар.

31. Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.
32. Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоол. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр. Улаанбаатар.
33. Бүсийн тулгуур төв хот тогтоох тухай. УИХ-ын 2003 оны 01 дугаар тогтоол. Улаанбаатар.
34. УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоол. Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулах тухай. Улаанбаатар.
35. БХБЯамны Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төвийн боловсруулсан “Монгол Улсын Бүлэг суурингийн тогтолцоо”-ны төсөл. 2006 он. Улаанбаатар.
36. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр. УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол. Улаанбаатар хот
37. “Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх онол аргазүйн үндэслэл, боломжит хувилбар”. Газарзүйн хүрээлэн. 2006 он. Улаанбаатар
38. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны Захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Барилга, хот байгуулалтын яамны Нутагшилт, суурьшлийн хэлтэс, ШУА-ын Газарзүйн хүрээлэнгийн хамтарсан “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх хувилбар” санал. Улаанбаатар 2005 он.